ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ 2021-2024 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## Нэг. Хяналт-шинжилгээний ажлын зорилго

Эрчим хүчний яамны 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан удирдлагыг бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 5.1 дэх заалтыг үндэслэв. Төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2, 6.2.3-т заасан аргачлалыг баримтлав.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Эрчим хүчний яамны 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан 6 ерөнхий чиг үүрэг, 23 үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх нийт 138 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөв.

*Хүснэгт 1. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, чиг үүргээр*

| Үндсэн чиг үүрэг | | Үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ | | Үнэлгээ |
|---|---|---|---|---|
| | | *Тоо* | *Хэрэгжил-тийн дундаж хувь* | |
| ***А*** | ***Эрчим хүчний болон эрчим хүчний түлшний талаарх бодлого, хууль тогтоомж, дүрэм журам боловсруулах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх*** | ***47*** | ***67.5%*** | ***Эрчимжүүлэх шаардлагатай*** |
| А.1 | Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, зах зээлийн бүтцийг боловсронгуй болгох бодлогын удирдамжаар хангах | 5 | 64.0% | Эрчимжүүлэх шаардлагатай |
| А.2 | Эрчим хүчний шинэ эх үүсвэр, шугам сүлжээ, үйлдвэрлэл, мэдээллийн технологийг хөгжүүлэхэд бодлогын удирдамжаар хангах | 27 | 64.5% | Эрчимжүүлэх шаардлагатай |
| А.3 | Эрчим хүчний нүүрс, хийн түлшний талаарх хууль тогтоомж, дүрэм, журмын төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах | 1 | 90% | Тодорхой үр дүнд хүрсэн |
| А.4 | Сэргээгдэх эрчим хүчний талаарх бодлого, хууль тогтоомж, дүрэм, журмын төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах | 5 | 64.0% | Эрчимжүүлэх шаардлагатай |
| А.5 | Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бодлогын удирдамжаар хангах | 9 | 76.6% | Тодорхой үр дүнд хүрсэн |
| ***Б*** | ***Эрчим хүчний бодлого, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, салбарын нэгдсэн үйлдвэрлэлийн*** | ***36*** | ***84.7%*** | ***Тодорхой үр дүнд хүрсэн*** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ***төлөвлөлт хийх, аюулгүй байдлыг хангуулах*** | | | |
| Б.1 | Эрчим хүчний салбарын бодлого, хууль тогтоомж, дүрэм, журам, төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, салбарын нэгдсэн үйлдвэрлэлийн төлөвлөлт хийж зохицуулах | 12 | 79.2% | Тодорхой үр дүнд хүрсэн |
| Б.2 | Эрчим хүчний систем, эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээ, барилга байгууламжийн найдвартай ажиллагаа, түүний ашиглалтын аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах, зохицуулах | 10 | 75.0% | Тодорхой үр дүнд хүрсэн |
| Б.3 | Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн найдвартай ажиллагаа, түүний ашиглалтын аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах | 3 | 83.3% | Тодорхой үр дүнд хүрсэн |
| Б.4 | Эрчим хүчний байгууламжийн аюулгүй байдлыг хангуулах болон эрчим хүчний барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулах, зохицуулах | 11 | 100% | Үр дүнтэй |
| ***В*** | ***Эрчим хүчний нүүрсний нөөцийг бүрдүүлэх, түлш, хийн ашиглалтыг нэмэгдүүлэх талаарх бодлого, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах*** | ***11*** | ***87.3%*** | ***Тодорхой үр дүнд хүрсэн*** |
| В.1 | Эрчим хүчний нүүрс, хийн талаарх хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах | 5 | 92.0% | Тодорхой үр дүнд хүрсэн |
| В.2 | Дулааны цахилгаан станц, дулааны станцуудын нүүрс болон сайжруулсан шахмал түлшний найдвартай хангамжийн талаар санал зөвлөмж боловсруулах, баланс гаргах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, арга зүйн удирдамжаар хангаж ажиллах | 4 | 92.5% | Тодорхой үр дүнд хүрсэн |
| В.3 | Хийн түлшний хангамжийн сүлжээ байгуулах, ашиглах талаар бодлогын хэрэгжилтийг зохицуулах, арга зүйн зөвлөгөө, удирдамжаар хангах | 2 | 65.0% | Эрчимжүүлэх шаардлагатай |
| ***Г*** | ***Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, төсвийн санхүүжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт, дотоод аудит хийх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, эрсдэлийн удирдлагаар хангах*** | ***12*** | ***90.0%*** | ***Тодорхой үр дүнд хүрсэн*** |
| Г.1 | Бодлогын зорилго, зорилт, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, үр нөлөөг үнэлэх, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг хэрэгжүүлэх | 3 | 100% | Үр дүнтэй |
| Г.2 | Салбарын эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хэрэгжүүлэх | 3 | 100% | Үр дүнтэй |
| Г.3 | Эрчим хүчний салбарын аюулгүй байдлыг хангах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх | 3 | 70.0% | Тодорхой үр дүнд хүрсэн |
| Г.4 | Гамшгаас хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах | 3 | 90.0% | Тодорхой үр дүнд хүрсэн |
| ***Д*** | ***Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах*** | ***23*** | ***79.5%*** | ***Тодорхой үр дүнд хүрсэн*** |
| Д.1 | Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үндсэн үүрэг хүлээж, төрийн захиргааны болон салбарын хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, аппаратад дотоод дэмжлэг үзүүлж удирдлага, ажилтнуудыг ажиллах хэвийн нөхцлөөр хангах | 12 | 65.8% | Эрчимжүүлэх шаардлагатай |
| Д.2 | Эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомж, бусад шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах | 6 | 95.0% | Тодорхой үр дүнд хүрсэн |
| Д.3 | Салбарын төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг зохион байгуулах | 2 | 100% | Үр дүнтэй |
| Д.4 | Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээллийн сан | 3 | 90.0% | Тодорхой үр |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | бүрдүүлэх | | | дүнд хүрсэн |
| ***Е*** | ***Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв боловсруулах, зарцуулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх, яамны аппаратын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах*** | ***9*** | ***93.3%*** | ***Тодорхой үр дүнд хүрсэн*** |
| Е.1 | Эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, концесс, төсөл хөтөлбөрийн үр ашгийг дээшлүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, хяналт тавьж ажиллах | 3 | 80.0% | Тодорхой үр дүнд хүрсэн |
| Е.2 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв боловсруулах, улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангах, худалдан авалтын үйл ажилгааг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах | 2 | 100% | Үр дүнтэй |
| Е.3 | Яамны аппаратын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах, яамны мөнгөн урсгалыг оновчтой төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавих | 4 | 100% | Үр дүнтэй |
| **ЕРӨНХИЙ ДҮН** | | **138** | **78.3%** | **ТОДОРХОЙ ҮР ДҮНД ХҮРСЭН** |

Эрчим хүчний яамны 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан нийт 138 арга хэмжээнээс 71 арга хэмжээ 100% хэрэгжиж үр дүн гарсан бол 37 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 25 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 5 арга хэмжээ үр дүнгүй гэж тус тус үнэлэгдэв. Нийт арга хэмжээний 51.5 хувь нь бүрэн хэрэгжсэн бол 44.9 хувь нь хэрэгжих шатанд, 3.6 хувь нь хэрэгжээгүй байна.

*Хүснэгт 2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, арга хэмжээгээр*

| Хэрэгжилтийн хувь | Арга хэмжээний тоо |
|---|---|
| **100 хувь - Үр дүнтэй** | 71 |
| **70-100 хүртэл хувь - Тодорхой үр дүнд хүрсэн** | 37 |
| **30-70 хүртэл хувь – Эрчимжүүлэх шаардлагатай** | 25 |
| **0-30 хүртэл хувь – Үр дүнгүй** | 5 |
| **Нийт** | **138** |

Үр дүн гараагүй, 0 хувиар үнэлэгдсэн 5 арга хэмжээ:

1. Даланзадгад-Ноён чиглэлийн 220 км 110 кВ-ын ЦДАШ, дэд станц барих /Хүрэх түвшин: ***Төслийн гүйцэтгэл 100%***/;
2. Эрчим хүчний салбарын инновацийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, удирдамжаар хангах /Хүрэх түвшин: ***Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулсан байна***/;
3. Аймгуудын төсөвт байгууллагуудыг дулааны эрчим хүчний тоолуураар тоолууржуулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх /Хүрэх түвшин: **Хэрэгжилт 100%**/;
4. Эрчим хүчний салбарын хүний нөөцийн бодлогын бичиг баримт боловсруулж, батлуулах /Хүрэх түвшин: **Бодлогын баримт бичиг батлагдсан байна**/;
5. Салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулах, зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийн үр дүн, нөлөөллийг үнэлэх /Хүрэх түвшин: **4-өөс доошгүй саналыг хэрэгжүүлсэн байна**/.

**Дөрөв. Дүгнэлт**

- Эрчим хүчний яамны 2021-2024 оны стратеги төлөвлөгөө 79.3 хувьтай хэрэгжсэн байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 138 арга хэмжээнээс 71 арга хэмжээ 100% хэрэгжиж үр дүн гарсан бол 37 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 25 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 5 арга хэмжээ үр дүнгүй гэж тус тус үнэлэгдэв. Нийт арга хэмжээний 51.5 хувь нь бүрэн хэрэгжсэн бол 44.9 хувь нь хэрэгжих шатанд, 3.6 хувь нь хэрэгжээгүй байна.

- Удаашралтай, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд нь санхүүжилт шийдвэрлэгдээгүй, мөн тендер шалгаруулалт, концесс эзэмшигчийг сонгон шалгаруулах, зээлийн хэлэлцээр, гэрээ байгуулах зэрэг төсөл, арга хэмжээний бэлтгэл, урьдчилсан шатны ажлууд удаашралтай явагдаж байгаатай холбоотойгоор хэрэгжилт хангалтгүй байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт тухайн оны зорилтот түвшинг хангасан, үр дүнтэй хэрэгжсэн байна.

Стратеги төлөвлөгөөний дэлгэрэнгүй биелэлтийг хавсаргав.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2024 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ 2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Стратеги /арга зам/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Биелэлт | Үнэл-гээний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ:** | | | | | | | |
| А.ЭРЧИМ ХҮЧНИЙ БОЛОН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТҮЛШНИЙ ТАЛААРХ БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРАМ БОЛОВСРУУЛАХ, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| ***А.1.Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, зах зээлийн бүтцийг боловсронгуй болгох бодлогын удирдамжаар хангах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 1 | **МУЗГҮАХ-3.5.4.** Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах инновац, шинэ техник технологи нэвтрүүлж, эрчим хүчний үнэ тарифыг үе шаттайгаар зах зээлийн зөв тогтолцоонд шилжүүлнэ. | ЗГҮАХХАХТ-3.5.4.2, Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах төслийг хэрэгжүүлэх /Эрчим хүчний төсөл-2/ | Төслийн гүйцэтгэл, хувиар | 20% | Төслийн гүйцэтгэл 100% | “ЭБЦТС” ТӨХК, “БЗӨБЦТС” ТӨХК-ийн хангах, түгээх үйл ажиллагаа явуулдаг Архангай, Өвөрхангай, Орхон, Булган, Хэнтий, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Багануур дүүрэг, Өвөрхангай аймгийн Хархорин, Дорноговь аймгийн Замын-Үүд, Хэнтийн аймгийн Бор-Өндөр сумын төвийн цахилгаан түгээх, дамжуулах шугам сүлжээг шинэчлэх, Багануур дүүрэг, Хэнтий аймаг, Говьсүмбэр аймгийн төвд хаалттай хуваарилах байгууламж барих, Ховд аймгийн Мянгад сумын дэд станцыг түшиглэн 10МВ-ын нарны ЦС барих, мөн сумын дэд станцыг шинэчлэх ажлууд тус тус хийгдэж байна. Төслийн нийт хэрэгжилт 99%-тай байна. 07 дугаар сард дуусгана. Энэ төслийн хүрээнд хэрэгжсэн “Мянгадын 10МВт”-ын нарны цахилгаан станц 2022 онд ашиглалтад орсон.<br>Төслийн хэмнэгдсэн хөрөнгөөр баруун 5 аймгийн 20 сумын төвийн цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажлыг 2023 он оны 4-р улирал шинээр эхлүүлсэн.<br>Баян-Өлгий аймагт ажлын гүйцэтгэл 56%, Ховд аймагт 80%, Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймагт 78%, Увс аймагт 32%-тай хэрэгжиж байна. 2024 оны 07 дугаар сард гэрээний хугацаа дууснa. | 90 |
| 2 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.6, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийг хэрэгжүүлэх | Төслийн гүйцэтгэл, хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 100% | МУ, ХБНГУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн дагуу 20,45 сая еврогийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих энэхүү төслийн хүрээнд Монгол Улсын хэмжээнд цахилгаан дамжуулах өндөр хүчдлийн 220, 110 кВ-ын дэд станцуудад ашиглагдаж буй ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл ихтэй 110 кВ-ын тосон болон хуурай тасалууртай гүйдлийн трансформатор, реле хамгаалалт удирдлагын хамтын шинэчлэх, төвийн бүсийн ЭХ-ний системийн гол зангилаа 220 кВ-ын 4 дэд станцын реле хамгаалалт, автоматик, хяналт, удирдлагын системийг бүрэн шинэчилж, өргөтгөх ажил хийгдэнэ. Төслийн зөвлөхөөр Герман Улсын Integration Umwelt& Energie компани гэрээ байгуулсан.<br>БУА-ын гүйцэтгэгч сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендер шалгаруулалтыг 2023 онд 2 удаа зохион байгуулсан. Үнэлгээний хороо тендерийн техникийн саналыг үнэлэх ажлыг 2023.10.13-2023.11.20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэн, 2023.11.29-ны өдөр хуралдаж, үнэлгээний тайланг KfW банкинд хүргүүлсэн. 2024 оны нэгдүгээр улиралд санхүүгийн саналыг нээж, үнэлгээ дуусган банкаар хянуулсан.<br>Төслийн барилга угсралтын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Олон улсын нээлттэй тендерт “Эм Си Эс” ХХК-г шалгаруулж, гэрээний хэлцэл хийж дууссан. | 30 |
| 3 | **ТЭХТББХДХХ-3.20.1.** Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, хэмнэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, | Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дагалдах журам, норм, нормативын баримт бичгүүдийг | Батлуулах журмын тоо | 4 журам хэрэгжиж байна. | Шинээр 2 журам батлагдсан байна. | Эрчим хүчний сайдын 2023 оны А/51 дугаар тушаалаар Эрчим хүчний хэмнэлтээр хэрэглээг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдаж, 2023 оны А/119 дүгээр тушаалаар арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний хүрээнд 2024.05.16-18-ны өдрүүдэд “Инноваци, Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг” сэдвээр Олон улсын үзэсгэлэн, хурлыг зохион байгуулсан. Эрчим хүчний сайдын 2024 оны А/123 дугаар тушаалаар Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулахаар ажиллаж | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дагалдах журам, норм, нормативын баримт бичгүүдийг боловсруулан гаргаж, үндэсний хэмжээнд хэрэгжилтийг хангах цогц арга хэмжээг авна. | боловсруулан гаргах /Урамшууллын журам, Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг шошгожуулах журам/ | | | | байна. | |
| 4 | **ТЭХТББХДХХ-3.18.2.** Эрчим хүчний салбарын шинжлэх ухаан, инновацийн технологийн судалгааны чадамжийг бэхжүүлж, шинэ бүтээл, инноваци, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжих, урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ. | Эрчим хүчний салбарын инновацийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой салбарын хэмжээнд мөрдөх дүрэм журам, норм, нормативын баримт бичгүүдийг боловсруулан гаргах | Боловсруулах нормативын баримт бичгийн тоо | Дэд хөтөлбөр батлагдсан | 2-оос доошгүй нормативын баримт бичиг боловсруу-лагдсан байна. | Техникийн хорооны 2024.06.12-ны өдрийн 2-р хурлаар MNS ISO 50046:2024 “Эрчим хүчний хэмнэлтийг таамаглах ерөнхий арга”, MNS ISO 50047:2024 “Эрчим хүчний хэмнэлт - Байгууллагын эрчим хүчний хэмнэлтийг тооцоолох”, MNS ISO 50049:2024 “Улс, бүс нутаг, хотын түвшинд эрчим хүчний үр ашиг болон эрчим хүчний зарцуулалтын өөрчлөлтийг тооцоолох арга” нэртэй **3 стандартын төслийг** хэлэлцүүлсэн. | 70 |
| 5 | | Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, шинэ төслүүдийн ТЭЗҮ, судалгааны ажлуудыг хэлэлцүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | Зөвлөлийн ажиллах журам шинэчлэн батлагдсан. | Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсан байна. | ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлыг тогтмол зохион байгуулж байна. Эрчим хүчний барилга байгууламж барьж байгуулах төслийн ТЭЗҮ-ийг холбогдох журмын дагуу ЭХЯ-ны ШУТЗ-өөр хэлэлцүүлж байна. | 100 |
| ***А.2.Эрчим хүчний шинэ эх үүсвэр, шугам сүлжээ, үйлдвэрлэл, мэдээллийн технологийг хөгжүүлэхэд бодлогын удирдамжаар хангах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 6 | **МУЗГҮАХ-3.5.1.** Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ. | ЗГҮАХХАХТ-3.5.1.1, Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг 46 МВт-аар нэмэгдүүлэн шинэчлэх | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 100% | Төслийг 2020-2021 онд хэрэгжүүлсэн. Ашиглалтад бүрэн орсон, суурилагдсан чадал 46 МВт-аар нэмэгдсэн. | 100 |
| 7 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.2, Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 80% | Төслийн БУА-ын гүйцэтгэгч компанитай 2021 онд Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ байгуулсан.<br>Гүйцэтгэгч 2021-2023 онд геологи, геофизикийн судалгааны ажлыг гүйцэтгэн, ажлын зураг төсөл хийгдсэн. Төслийн талбайд ЦДАШ барих, ашиглалтын 40 км зам барих, бараа материалын агуулах, гаалийн баталгаат агуулах, төмөр модон материал бэлдэх үйлдвэр, техник засварын цехийн БУА эхэлсэн, үндсэн кемпийн 3 барилгыг барьж, Ховд гол дээр түр гүүрний тулгуурын суурийн цутгалтын ажлууд хийгдсэн.<br>“Эрдэнtбүрэнгийн усан цахилгаан станц барих” төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээр байгуулах зөвшөөрлийг БНХАУ-ын Төрийн зөвлөлөөс олгосон талаар БНХАУ-ын ЭКСИМ банкнаас 2024.03.21-ний өдөр мэдээлсэн болно. БНХАУ-ын Экспорт-Импорт банкнаас тусгайлсан зээлийн хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Сангийн яаманд ирүүлж, тус яамны 2024.04.18-ны өдөр хариу албан бичгийг хүргүүлсэн. БНХАУ-ын ЭКСИМ банкнаас хариу хүлээж байна. | 30 |
| 8 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.3, Чойбалсангийн дулааны цахилгаан | Гүйцэтгэлийн хувиар | Төслийн явц 10% | Төслийн гүйцэтгэл 100% | Төслийг МУ-ын төсвийн хөрөнгө оруулалт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн. Төслийн барилга байгууламжийн угсралтын ажил дууссан.<br>Станцыг 2024.05.09-ний өдөр ажиллагаанд залгаж, 06-р сарын 06-ны өдөр ашиглалтад | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | | станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх | | | | оруулах нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Туршилт тохируулгын ажил явагдаж байгаа бөгөөд байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комиссын өмнөх үндсэн, туслах тоноглол бүрээр үе шаттай техникийн комисс ажиллаж байна. | |
| 9 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.4, Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 80% | Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021-2022 онд 2 удаа зохион байгуулж, амжилтгүй болсон. ЗГ-ын 2023.04.12-ны өдрийн 132 дугаар тогтоолоор 2023.06.12-ны өдөр дахин зарласан "Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих Тавантолгой 450МВт-ын дулааны цахилгаан станцын эхний ээлжийн 300МВт-ын гүйцэтгэгч болон санхүүжүүлэх эх үүсвэрийг сонгон шалгаруулах" тендер мөн амжилтгүй болсон. Төслийн худалдан авах ажиллагааны үе шатанд маргаан гарч тендерт оролцогч "Митайм" ХХК-иас Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд ЭХЯ-нд холбогдуулан нэхэмжлэл гаргасан. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс шүүх хурлыг 2024.03.07-ны өдөр хийсэн боловч шүүх хуралд оролцогч түншлэгч компаниас "шүүгчээс татгалзах татгалзал гаргасан"-тай холбоотойгоор шүүх хурал хойшилсон ба татгалзлыг хүлээн авсан Ерөнхий шүүгч шинээр шүүгч томилсон. Шүүх хурлыг 2024.06.03-ны өдөр хийхээр товлосон боловч дахин хойшилсон. | 30 |
| 10 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.5, Төвийн, зүүн болон говийн бүсийн нүүрсний орд газруудыг түшиглэн 300-400 МВт-ын цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 80% | Төв аймгийн Баянжаргалан суманд эхлүүлсэн Бөөрөлжүүтийн 300 МВт-ын цахилгаан станцын эхний 150 МВт-ын блокын барилга угсралтын ажил 65 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>ЭХЯ-наас "Цэцэнс майнинг энд энержи" ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу Бөөрөлжүүтийн төслийн хүрээнд нэмэгдсэн өртгийн татвар төлөх хугацааг сунгах, гаалийн татвараас чөлөөлөх гурван талт гэрээ байгуулах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар шийдвэрлүүлж өгөх хүсэлтийг 2024.01.22-ны өдрийн а/248 тоот албан бичгээр СЯ-д хүргүүлсэн. СЯ-наас ЗГ-ын тогтоолын төсөлд холбогдох яамдуудаас саналыг авч нэгтгэн, ЗГХЭГ-т хүргүүлсэн. МУЗГ-ын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор Бөөрөлжүүтийн 300 МВт-ын цахилгаан станцын төслийн барилга угсралтад зориулан импортоор оруулж ирэх тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах НӨАТ-ын төлөх хугацааг 4 жилийн хугацаагаар сунгахаар шийдвэрлэсэн. Уг тогтоолын дагуу СЯ, ЭХЯ, Төсөл хэрэгжүүлэгч хооронд байгуулах гурван талт гэрээний төслийг боловсруулан, баталгаажуулах ажил хийгдэж байна.<br>Багануурын ДЦС төслийн хувьд БНХАУ-ын гадаад улсад нүүрсээр ажилладаг эх үүсвэр барих бодлого, шийдвэртэй холбогдуулан "Багануур пауэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигч БНХАУ-ын "Цөмийн инженерийн барилга групп" ТӨХК нь төслийн хяналтын багц хувьцааг шилжүүлэх хүсэлтийг концесс олгогч буюу ЭЗХЯ-нд 2022 оны 08 дугаар сард гаргасан бөгөөд ЭЗХЯ-наас хувьцаа шилжүүлэхийг дэмжиж, төслийн барилга угсралтын ажлыг эрчимжүүлэхийг мэдэгдсэн.<br>Үүний дагуу концесс эзэмшигчийн зүгээс төслийн хяналтын багц хувьцааг шилжүүлэх хэлцлийг БНХАУ-ын Касень групп компанитай 2023 онд хийсэн.<br>Эрчим хүчний сайдын 2024.01.10-ны өдрийн а/78 тоот албан бичгийг концесс эзэмшигч "Багануур Пауэр" ХХК, хөрөнгө оруулагч буюу "Хятадын үндэсний цөмийн корпораци" ХК-д тус тус хүргүүлж, төслийн компанийн хяналтын багц хувьцаа шилжүүлэх ажлыг эрчимжүүлж, барилга угсралтын ажлыг эхлүүлэхийг мэдэгдсэн. Гэвч "Багануур Пауэр" ХХК-иас Касень групп компанитай хийсэн хэлцэл амжилтгүй болсон бөгөөд хөрөнгө оруулалтын түншүүдийг идэвхтэй хайж хувьцаа шилжүүлэх ажлыг дуусгах тухайгаа 2024.03.19-ний өдрийн хариу албан бичгээр Эрчим хүчний яаманд ирүүлсэн. Хятадын талын хөрөнгө оруулагч компанийн хувьцаа шилжүүлэх ажлаас шалтгаалан төслийн хэрэгжилт түр зогсонги байдалд орсон. | 50 |
| 11 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.6, 160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барих | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 100% | Төслийг бүрэн хэрэгжүүлсэн. Эрчим хүч хуримтлуурын системийг 2023.12.07-ны өдөр хүчдэлд залгасан бөгөөд батлагдсан горимын дагуу диспетчерийн даалгавраар нэгдсэн сүлжээнд 80 МВт хүртэлх чадал, 212 МВт.ц хүртэл энерги нийлүүлж оргил ачааллад оролцож байна. Төслийн талбай доторх авто зам гадна тохижилтын ажлуудыг бүрэн дуусгаж, төслийн нээлтийг 6 дугаар сард багтаан зохион байгуулахаар бэлтгэл ажлууд хийгдэж байна. Төслийн нийт барилга угсралтын ажлын гүйцэтгэл 98%. Нээлттэй холбоотой бэлтгэл ажлуудыг зохион байгуулахад төсөл хэрэгжүүлэх нэгж, гүйцэтгэгчид | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэмжлэг үзүүлэн, бодлогын удирдамжаар ханган ажиллаж байна. | |
| 12 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.7, Амгалангийн дулааны станцын хүчин чадлыг хосолмол 50МВт-аар нэмэгдүүлэх | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 100% | Амгалан дулааны станцыг 116 МВт (100 Гкал/ц) хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөх төслийн БУА-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2022 онд “Хунан индастриал экүйпмент инсталэйшн” ХХК-тай түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ байгуулсан.<br>Төслийн санхүүжилтийг Хөгжлийн банкны охин компани “Ди Би Эм лизинг” ХХК-тай санхүүгийн түрээсийн гэрээ байгуулан санхүүжүүлж байна.<br>Төслийн барилга угсралтын ажлыг дуусгаж, өргөтгөлийн зуухны галлагаа, туршилтыг 2024.03.29-ний өдөр эхлүүлсэн бөгөөд туршилтын ажил хэвийн, үр дүнтэй болсноор станцын өргөтгөлийн нээлтийн үйл ажиллагааг 2024.04.19-ний өдөр зохион байгуулж ашиглалтад оруулсан. Улсын комисс ажиллуулах, баталгаат хугацааны санхүүжилт болон магадлашгүй ажлын санхүүжилт олгогдоогүй хүлээгдэж байна. | 100 |
| 13 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.8, Дулааны хоёрдугаар цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станцын ажлыг эхлүүлэх | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 50% | Концесс эзэмшигчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах холбогдох албан тушаалтны нэрийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Хийн цахилгаан станц барихад хий хангамжийн дэд бүтцийг шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудлууд ихээхэн гарч байгаа тул энэ төслийн зэрэгцээ Дулааны 2-р цахилгаан станцын бэлэн дэд бүтцийг ашиглан 300 МВт-ын дулааны цахилгаан станц барих төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж байна.<br>Эрчим хүчний сайдын тушаалаар холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулагдсан ДЦС-2-ын төслийн дэд бүтцийн трассын судалгаа хийх, дүгнэлт гаргах ажлын хэсгийн хүрээнд төмөр замын дэд бүтцийн асуудлаар дэмжлэг үзүүлэх хүсэлтийг "Улаанбаатар төмөр зам ХНН"-д хүргүүлсэн.<br>УБТЗ, ЗТХЯ-ны хамтарсан ажлын хэсгийн "Салбар төмөр зам барих" 24/46/07 тоот техникийн нөхцөлийн дүгнэлт, дулааны шугам, ЦДАШ-ын трассыг тогтоож “ДҮТ” ТӨХХК-иар горим тооцооны дүгнэлтийг гаргуулсан. | 30 |
| 14 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.9, Нийслэлийн Багануур, Налайх дүүргүүдэд дулааны станцын өргөтгөл шинэчлэлт хийх; эрчим хүчний шинэ эх үүсвэр, дэд станц шинээр бий болгох | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 100% | Нийслэлийн Багануур, Налайх дүүргүүдэд дулаан хангамжийн шинэ эх үүсвэр барих ТЭЗҮ-г 2022 онд баталсан. Дулааны станцуудыг барих хөрөнгө оруулалтын зардал улсын төсөвт тусгагдаагүйгээс барилга угсралтын ажлыг эхлүүлэх боломж бүрдээгүй байна.<br>Нийслэлийн Налайх дүүрэгт дулааны станцын шинэ эх үүсвэрийн хүрээнд газрын асуудлыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн газрын зөвшөөрлийг гаргуулсан. Налайх дүүрэгт 216 МВт-ын дулааны шинэ станцыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих төсөл, арга хэмжээг 2024 оны 05 дугаар сард УИХ-аар батлагдсан Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусган батлуулсан. | 30 |
| 15 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.10, Эрдэнэтийн Дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөх | Гүйцэтгэлийн хувиар | Төслийн явц 80% | Төслийн гүйцэтгэл 100% | Төслийг 2020-2021 онд хэрэгжүүлсэн. Өргөтгөл ашиглалтад бүрэн орж, станцын суурилагдсан чадал 35 МВт-аар нэмэгдсэн. | 100 |
| 16 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.11, Дулааны гуравдугаар цахилгаан станцыг 325 МВт-аар өргөтгөх ажлыг эхлүүлэх | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 50% | “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл, төсөв боловсруулах тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулж, тус хэлэлцээрийн төсөлд Эдийн засаг, хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Гадаад харилцааны яамдын саналыг авч нэгтгэн тусгаж, Засгийн газрын 2024.04.17-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.<br>Дулааны гуравдугаар цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 300 МВт-аар өргөтгөх шинэчлэлийн төслийн зураг төсөл, төсөв боловсруулах тухай Монгол, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд санал авах тухай Эрчим хүчний сайдын 2024.04.25-ны өдрийн а/1231 тоот албан бичгийг ОХУ-ын Эрчим хүчний сайдад хүргүүлсэн. | 30 |
| 17 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.12, Эгийн голын 315 | Гүйцэтгэлийн хувиар | 30% | Дэлхийн өвийн хороонд хүргэгдсэн | Төслийн зөвлөх Франц Улсын “БРЛ Инженер” компани, МУ-ын “Престиж Инженеринг” ХХК, “Санни Трейд” ХХК-ийн түншлэлийн гүйцэтгэсэн “Эгийн голын УЦС төслийн Сэлэнгэ мөрөн, Байгаль нуурт үзүүлэх биологийн олон янз байдлыг тодорхойлох нэмэлт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | МВт-ын хүчин чадал бүхий усан цахилгаан станц төслийн байгаль орчинд үзүүлэх олон талт нөлөөллийн судалгааг хийж, дэлхийн өвийн хороонд тайлагнаж зохих шийдвэр гаргуулах | | | байна. | судалгаа”-ны ажлын эцсийн тайланг БОАЖЯ-ны Мэргэжлийн зөвлөлөөр 2022 оны 11-р сард, Усны зөвлөлөөр 12-р сард тус тус хэлэлцүүлсэн.<br>Эгийн голын УЦС төслийн Биологийн олон янз байдлын үнэлгээний тайланг ДӨХ-нд хүргүүлэх асуудлаар ЭХЯ, ГХЯ, БОАЖЯ, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын НБД болон “Эгийн голын УЦС” ТӨХХК зэрэг холбогдох албаны хүмүүс 2023.01.11-ний өдрөөс Дэлхийн өвийн төвтэй цахим хурал хийх, Дэлхийн өвийн үндэсний хорооны 2023.02.06-ны өдрийн хуралд судалгааны ажлын үр дүнг танилцуулах, ОХУ-ын талаас хүссэний дагуу төслийн судалгаа болон УЦС-ын дүүргэлт ба ашиглалт ажиллагааны үед Сэлэнгэ мөрөнд сөрөг нөлөө үзүүлэхгүй байгалийн горимын нөхцөлийг хангах техникийн арга хэмжээний судалгааны товч тайланг ОХУ-ын Эрчим хүчний сайдад ГХЯ-аар дамжуулан хүргүүлэх зэргээр харилцан хамтран ажиллаж, тайланг ЮНЕСКО-д хүргүүлсэн.<br>2023.09.10-25-ны өдрүүдэд Саудын Арабын Хаант Улсын Рияд хотноо зохион байгуулагдсан ЮНЕСКО-ийн Дэдлхийн өвийн хорооны 45-р чуулганаар хэлэлцэн, МУ, ОХУ-ын талуудыг БНБОҮ-ний дүгнэлтэд үндэслэн одоо байгаа болон ирээдүйд барихаар төлөвлөж буй бүх УЦС, усны менежментийн төслүүдийн Байгаль нуурын Дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэт байдалд үзүүлэх Хуримтлалын нөлөөллийн үнэлгээг хамтран боловсруулах шийдвэр гарсан.<br>Энэтхэг Улсад 2024.07.21-31-ний өдрүүдэд зохион байгуулагдах ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хорооны 46-р ээлжит чуулган оролцох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дэлхийн өвийн төвд хүргүүлэх “Эгийн голын УЦС” төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, усны судалгаанууд болон тус төвд 2023 онд хүргүүлсэн төслийн “Сэлэнгэ мөрөн, Байгаль нуурын биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийн нэмэлт судалгаа”-ны тайланг тус чуулганаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэхийг хүссэн 2024.01.25-ны өдрийн а/274 дугаар албан бичгийг ГХЯ-нд хүргүүлсэн. | |
| 18 | | ЗГҮАХХАХТ-3.5.1.13, Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй дулаан цахилгааны хэрэгцээг хангах шинэ эх үүсвэр байгуулах ТЭЗҮ боловсруулах | Ажлын гүйцэтгэлээр | 0% | ТЭЗҮ батлагдсан байна. | “Улаанбаатар хотын шинэ дагуул хотуудыг түшиглэн баригдах дулаан, цахилгааны эх үүсвэрийн ТЭЗҮ” боловсруулах ажлыг 2021-2022 онд гүйцэтгэж, ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн дэмжсэн.<br>Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа дулааны хэрэглээг хангах зорилгоор төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлыг ЭХЯ-ны захиалгаар 2021 онд "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ боловсруулан тус яамны ШУТЗ-ийн 2021.12.21-ний өдрийн хурлаар хэлэлцэн дэмжсэн. Уг ТЭЗҮ-д 2024 онд тодотгол оруулан сайжруулж мөн зөвлөлийн 2024.03.05-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжсэн. | 100 |
| 19 | **МУЗГҮАХ-3.5.3.** Төвлөрсөн хот, сум, суурин газарт дулааны эх үүсвэр шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна. /Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Дундговь, Говьсүмбэр, Төв, | ЗГҮАХХАХТ-3.5.3.1, Арван аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв шинээр барих /Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв/ | Гүйцэтгэлийн хувиар | 5% | Төслийн гүйцэтгэл 100% | Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Говь-Алтай, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр, Төв, Дундговь аймгийн гүйцэтгэгчээр шалгарсан Бюксан Инженеринг компанитай 2021.12.27, 2022.08.25--ны өдрүүдэд гэрээ байгуулж, төслийн БУА-ыг эхлүүлсэн.<br>9 аймаг /Архангайгаас бусад/-ийн БУА-ын ерөнхий гүйцэтгэл 43-49 хувьтай үргэлжилж байна. Аймгуудад дулааны станцын үндсэн тоноглол болох зуухны угсралтын ажил хийгдэж байгаа ба туслах тоноглол утаа сорогч, түлш дамжуулах систем, цахилгааны барилгын угсралтын ажлууд хийгдсэн.<br>Архангай аймгийн төвд баригдах дулааны станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2024.04.30-ны өдөр нээхэд оролцогч ороогүй, тендер амжилтгүй болсон.<br>Иймд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, дахин зарлах шийдвэр гарч, төслийн зөвлөх компани ажиллаж байна. | 43.1 |
| 20 | | ЗГҮАХХАХТ-3.5.3.2, Нийслэл, орон нутгийн дулааны шугам сүлжээг үе шаттайгаар өргөтгөх, шинэчлэх | Гүйцэтгэлийн хувиар | - | Батлагдсан төсвийн хүрээнд ажил хийгдсэн байна. | Нийслэл, орон нутгийн дулааны шугам сүлжээг үе шаттайгаар өргөтгөж, шинэчлэх ажлын хүрээнд жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж байна. 2024 оны төсвийн тухай хуулиар Эрчим хүчний сайдын багцад 12 төсөл арга хэмжээ батлагдсан. Үүнээс 2 төсөл арга хэмжээ шилжиж, 10 төсөл арга хэмжээ шинээр хэрэгжиж байна. Шилжин хэрэгжиж буй 2 ажлын барилга угсралтын ажил 85 хувьтай үргэлжилж байна. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, гэрээ байгуулах шатанд | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Сүхбаатар, Хэнтий аймагт дулааны станц барина./ | | | | | байна. | |
| 21 | | 3ГҮАХХАХТ-3.5.3.3, Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 100% | Төслийн хүрээнд 2021-2023 онд Улаанбаатар хотын дулаан дамжуулах төв шугамд Ф350-1000 мм-ийн голчтой нийт 8673 хос.м дулааны шугамыг өргөтгөн шинэчлэх, дулааны өргөх нэг насос станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлууд хийгдсэн.<br>2024-2025 онд үлдэгдэл санхүүжилт болох 19 сая ам долларын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлуудын төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Төлөвлөлтийн дагуу 2024 онд нийт 3280 хос.м дулааны шугамын өргөтгөл шинэчлэлийн ажлыг эхлүүлсэн.<br>Төсөл хэрэгжих хугацаа 2025 онд дуусах бөгөөд 2024 оны хагас жилийн байдлаар төслийн нийт хэрэгжилт 65%-тай байна. | 65 |
| 22 | | 3ГҮАХХАХТ-3.5.3.4, Улаанбаатарын хотын дулаан хангамж төслийг хэрэгжүүлэх | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 100% | 2021-2022 онд дулааны төв 8-р магистралийн Ф600 мм голчтой 3,3 хос.км дулааны шугам 5,12-р магистралийн холбоос 0,5км хос.дулааны шугам, бичил хороололд шинээр 0,6 хос.км дулааны шугам, нийт 4,4 хос.км шугам угсарсан.<br>2023-2024 онд нийт 6.6 км урт дулааны шугам шинээр хийж гүйцэтгэхээр барилга угсралтын ажлуудыг эхлүүлсэн, ажил үргэлжилж байна. Үүнд:<br>- Бичил хорооллыг хангах дулааны шугам шинээр татах БАГЦ-2 ажил /2Ф400 мм, 0.6 хос км/<br>- Амгалан орчмын дахин төлөвлөлтийг хангах дулааны шугам шинээр татах /2Ф400мм, 1.8 хос.км/<br>- Толгойт орчмын дахин төлөвлөлтийг хангах дулааны шугам шинээр татах /2Ф400мм, 4.2 хос.км/<br>- Хэрэглэгчийн төлбөр тооцоонд ашиглах ухаалаг тоолуур суурилуулах<br>- Алсын удирдлага, хяналтын системтэй цахилгаан активатор бүхий бөмбөлгөн хаалт суурилуулах юм.<br>Төсөл хэрэгжих хугацаа 2024 онд дуусах боловч газар чөлөөлөлт болон бусад хүчин зүйлсүүдээс шалтгаалан 2025 онд үргэлжлэхээр байна.<br>2024 оны эхний хагас жилийн байдлаар төслийн нийт хэрэгжилт 68.9%-тай байна. | 68.9 |
| 23 | | 3ГҮАХХАХТ-3.5.3.5, Арван аймгийн төвд баригдах дулааны станцын дэд бүтцийг байгуулах, дулаан түгээх сүлжээг шинэчлэх, шинээр барих | Ажлын гүйцэтгэлээр | 0% | Батлагдсан төсвийн хүрээнд ажил хийгдсэн байна. | 10 аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтцийн 100,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2024-2025 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн ба МУ-ын 2024 төсвийн тухай хуулиар 51,342.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2024-2026 онд хэрэгжүүлэхээр батлагдсан бөгөөд 2024 онд санхүүжих дүн нь 21,888.7 сая төгрөг байна. Төсөвт батлагдсан ажилд гүйцэтгэгчийг шалгаруулах 21 багц тендерүүдийг зарласан.<br>10 аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтцийн ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах 21 багц тендерүүдийг зарласан. Үүнээс Архангай /цахилгаан, дэд бүтэц 1 багц/, Дундговь /цахилгаан 1 багц/, Төв /цахилгаан, дулаан, ус хангамжийн 2 багц/, Хэнтий /цахилгаан 1 багц/, Өвөрхөнгай /цахилгаан 1 багц/ аймгийн нийт 6 багцад гэрээ байгуулагдсан, Баянхонгор /цахилгаан, дулаан, ус хангамж 2 багц/, Дундговь /дулаан, ус хангамж 2 багц/, Завхан /цахилгаан, дулаан, ус хангамжийн 2 багц/ Сүхбаатар /цахилгаан, дулаан, ус хангамжийн 1 багц/, Говьсүмбэр /цахилгаан, дулаан, ус хангамжийн 2 багц/ нийт 9 багц тендерийн шатанд, Говь-Алтай /цахилгаан, дулаан, ус хангамжийн 2 багц/, Хэнтий /дулаан, ус хангамжийн 2 багц/, Өвөрхангай /ус хангамжийн 1 багц/, Говьсүмбэр /цахилгаан 1 багц/ 6 багцын тендерийг дахин зарласан | 50 |
| 24 | | 3ГҮАХХАХТ-3.5.1.6, Орон нутгийн дулааны станцын өргөтгөл, шинэчлэл болон эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах /Багануур дүүрэг, Хөвсгөл аймаг Хатгал, Өвөрхангай | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | 0% | Хөрөнгө оруулалт шийдвэрлэгд-сэн байна. | Нийслэлийн Багануур дүүргийн дулаан хангамжийн эх үүсвэрийн ТЭЗҮ, Хөвсгөл аймгийн Хатгал сумын шинэ дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ, Өвөрхангай аймгийн Баянтээгийн уурхайг түшиглэн цахилгаан станц барих ТЭЗҮ-ийг 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр боловсруулж, ЭХЯ-ны ШУТЗ-өөр хэлэлцэн баталсан.<br>Хөрөнгө оруулалтын асуудлаар гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахгүй, нүүрсний станцуудад гадны хөрөнгө оруулалт татах боломжгүй байгаа тул улсын төсөвт тусгах саналыг хүргүүлсэн боловч төсвийн хязгаараас шалтгаалан шийдвэрлэгдэхгүй байна.<br>Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд зураг төслийн санхүүжилтийг тусгуулахаар санал хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй, хасагдсан байна. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | аймаг Баянтээг/ | | | | | |
| 25 | | Улаанбаатар хотын гэр хорооллын барилгажилттай уялдуулан алслагдсан дүүргүүдэд хэсэгчилсэн дулаан хангамжийн систем байгуулах төслийг үе шаттайгаар эхлүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | 0% | Хэсэгчилсэн дулаан хангамжийн төслүүдийг хэрэгжүүлсэн байна. | Улаанбаатар хотын гэр хорооллын барилгажилттай уялдуулан алслагдсан дүүргүүдэд хэсэгчилсэн дулаан хангамжийн систем байгуулах төслийг Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу Нийслэлийн гэр хорооллын дэд бүтэц төслийн хүрээнд хэрэгжүүлж байна. Дэнжийн мянга, Дамбадаржаа, Сэлбэ дэд төвүүдийн дулаан хангамжийн эх үүсвэрийн ТЭЗҮ-үүд батлагдан Сэлбэ дулааны станц ашиглалтад орсон. | 70 |
| 26 | | Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд оргил ачааллын горимд ажиллах эх үүсвэр, дулаан хуримтлуурыг ашиглах судалгаа хийх, төслийн бэлтгэл хангах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | 0% | Төслийн суурь судалгаа хийгдсэн байна. | Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа дулааны хэрэглээг хангах зорилгоор төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлыг ЭХЯ-ны захиалгаар 2021 онд "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ боловсруулан тус яамны ШУТЗ-ийн 2021.12.21-ний өдрийн хурлаар хэлэлцэн дэмжсэн. Уг ТЭЗҮ-д 2024 онд тодотгол оруулан сайжруулж мөн зөвлөлийн 2024.03.05-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжсэн. ТЭЗҮ-ээр 4 байршилд буюу БЗД-ийн 26-р хороонд Цэцэрлэгт хүрээлэн орчмын 2 байршилд 112 МВт, 84 МВт хүчин чадалтай 2 эх үүсвэр, БЗД-ийн 4-р хороо, Их засаг их сургууль, Маахуур толгойн дэргэд 46 МВт хүчин чадалтай 1 эх үүсвэр, ХУД-ийн 11-р хороонд 28 МВт хүчин чадалтай 1 эх үүсвэр, нийт 270 МВтын нийлбэр хүчин чадалтай 4 хийн эх үүсвэр барих судалгаа хийгдсэн.<br>Эдгээрээс эхний ээлжинд БЗД-ийн 26-р хороонд Цэцэрлэгт хүрээлэнгийн байршилд 112 МВт хүчин чадалтай хийн эх үүсвэр барихаар хөрөнгийг МУ-ын 2024 оны төсөвт тусган, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад “XVII.1.41. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллалд ажиллах тархмал дулааны эх үүсвэр /Улаанбаатар/” төсөл, арга хэмжээ батлагдаж, 2024 онд 20.0 тэрбум төгрөгийг баталсан.<br>Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулах үнэлгээний хороог ЭХЯ-ны ТНБД-ын 2024.01.22-ны өдрийн А/17 дугаар тушаалаар байгуулсан. Тендерийг 2024.06.05-ны өдөр зарласан. | 100 |
| 27 | **МУЗГҮАХ-3.5.5.** Бүс нутгийн эрчим хүчний сүлжээг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбож, уул уурхай, хүнд үйлдвэрийн мега төслүүдийн цахилгаан хангамжийг үе шаттайгаар шийдвэрлэж, ухаалаг систем бий болгоно. /Чойр-Сайншандын 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын | ЗГҮАХХАХТ-3.5.5.1, Чойр-Сайншанд 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барих | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 100% | МУЗГ, ЕСБХБ хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд 56,6 сая ам.доллараар Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төслийг хэрэгжүүлж байна. Төслийн ТЭЗҮ, БОННҮ-ний тайлан, зураг төсөв, трасс баталгаажуулах ажлууд бүрэн хийгдсэн. Төслийн зөвлөхөөр шалгарсан компанитай гэрээний хэлцлийг хийж, 2024.03.03-ны өдөр гэрээг байгуулсан.<br>Төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооноос ЕСБХБ-ны зөвшилцлөөр урьдчилсан шалгаруулалттай нэг шатлалт тендер зарласан. Тендерийн үнэлгээ хийгдэж байна. | 30 |
| 28 | | ЗГҮАХХАХТ-3.5.5.2, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 80% | Монгол Улс болон АХБ хооронд байгуулах "2022-2023 оны зээлийн төлөвлөгөөний санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийг УИХ 2023.06.09-ны өдөр соёрхон батлалснаар Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн ЦДАШ барих төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газрын 2023.08.23-ны өдрийн 323 тоот тогтоол гарсан.<br>АХБ-ны 44 сая ам долларын зээлээр төслийг 2024-2026 онд хэрэгжүүлнэ.<br>Эрчим хүчний сайдын 2024.01.24-ны өдрийн а/194 тоот албан бичгээр төслийн зээлийн тусгайлсан хэлэлцээр хийхэд дэмжлэг хүссэн албан бичиг Сангийн сайдад хүргүүлсэн. Сангийн сайдаас 2024.03.06-ны өдрийн 01/1348 тоот албан бичгээр АХБ-ны хамгаалалтын бодлоготой нийцүүлэх шаардлага биелүүлсэн тохиолдолд зээлийн тусгайлсан хэлэлцээр байгуулах боломжтой талаар мэдэгдсэн. АХБ-ны хамгаалалтын бодлоготой нийцүүлэх талаар ажиллаж байна.<br>Төслийн ТЭЗҮ, зураг төсөл 2022 онд, байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ 2023 онд хийгдсэн ба санхүүжилтийн гэрээ байгуулах бусад бэлтгэл ажлууд /трасс г.м/ бүрэн | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шугам, дэд станцыг барина/ | | | | | дууссан, Эрдэнэбүрэнгийн УЦС-ын зээлийн тусгайлсан гэрээ байгуулагдмагц, энэхүү төслийн зээлийн тусгайлсан гэрээ байгуулагдахад бэлэн болсон байна. | |
| 29 | | ЗГҮАХХАХТ-3.5.5.3, Даланзадгад-Ноён чиглэлийн 220 км 110 кВ-ын ЦДАШ, дэд станц барих | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 100% | ТЭЗҮ батлагдсан. Барилга угсралтын ажлын санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй. | 0 |
| 30 | | ЗГҮАХХАХТ-3.5.5.4, Тайширын УЦС-аас Есөнбулаг сум хүртэл 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих | Гүйцэтгэлийн хувиар | 0% | Төслийн гүйцэтгэл 100% | Тайширын УЦС–аас аймгийн төв уруу татах 110 кВ-ын ЦДАШ, дэд станц /Говь-Алтай/ төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр 2019 онд эхлүүлсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах явцад маргаан үүсэж төсөл удааширсан. Улмаар тендер дахин зарлагдаж, 2021 онд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. Одоогийн байдлаар 110 кВ-ын ЦДАШ-ын 53.27 км ЦДАШ-ын угсралтын ажил, 110/35/6 кВ-ын 1x10 МВА дэд станцын угсралтын ажил бүрэн дууссан, БУА-ын гүйцэтгэл 95%-тай, улсын комисс ажиллуулахаар бэлтгэл хангаж байна. | 95 |
| 31 | | ЗГҮАХХАХТ-3.5.5.5, Нийслэл, орон нутгийн цахилгааны шугам сүлжээг үе шаттайгаар өргөтгөх, шинэчлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Батлагдсан төсвийн хүрээнд ажил хийгдсэн байна. | Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, хүчдэлийн уналттай нийт 9061 айл өрхийн цахилгаан хангамжийг сайжруулах 29.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг 2022 онд эхлүүлсэн ба барилга угсралтын ажил 25-аас 60 хувьтай үргэлжилж байна.<br>2023 онд эхэлсэн “Нийслэлийн гэр хорооллын айл өрхөд 4кВт-ын хүчин чадалтай 5012 айл өрхийг цахилгааны халаагуур ашиглах техникийн боломж бүрдүүлэх” төсөл арга хэмжээний нийт 12 багц барилга угсралтын ажил хийгдэж байна. Барилга угсралтын ажил 60-95 хувьтай үргэлжилж байна. | 90 |
| 32 | | ЗГҮАХХАХТ-3.5.5.6, Цахилгаан дамжуулах шугам сүлжээний ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах /Мандалговь-Арвайхээр, Багануур-Чойр, Багануур-Чингис-Чойбалсан, Багануур-Налайх-Сонгино, Сайншанд-Цагаансуварга, Дархан-Сонгино чиглэлийн шинээр барих 220 кВ-ын ЦДАШ, дэд станц, 220 кВ-ын Оюут дэд станц/ | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | 0% | Хөрөнгө оруулалт шийдвэрлэгд-сэн байна. | Мандалговь-Арвайхээр, Багануур, Чойр, Багануур-Чингис-Чойбалсан, Багануур-Налайх, Сонгино, Сайншанд-Цагаансуварга, 220 кВ-ын Оюут дэд станц, Дархан-Сонгино, шинээр барих 110 кВ-ын дэд станцуудын зураг төслийг 2021-2022 онуудад хийж гүйцэтгэсэн.<br>Багануур-Чойрын 220 кВ-ын ЦДАШ, дэд станцуудын өргөтгөл төслийг Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Санхүүжилтийн эцсийн шийдвэрийг гаргуулахаар банкны Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэх шатанд байна. Төслийн БОННҮ-нд нүүдлийн шувуудын бүс нутгийг дайран өнгөрөх шугамын трассыг өөрчлөх дүгнэлт гарч БОАЖЯ-нд хүргүүлсэн. Тус яамны дүгнэлт хүлээгдэж байна. Ажлын зураг төсөл хийсэн "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ ЦДАШ-ын трасс өөрчлөн батлуулахаар ажиллаж байна. Сангийн яамнаас шугамын трасс эцэслэн батлагдвал зээлийн тусгайлсан хэлэлцээр байгуулах талаар мэдэгдсэн. Төслийн зээлийн хэлэлцээр хийх ажлын хэсэгт ажиллах албан хаагчдын нэрсийг Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Мандалговь-Арвайхээрийн 220 кВт-ын ЦДАШ барих төслийг Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр банктай урьдчилан тохиролцсон. “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын үндэсний хорооны 2023.06.05-ны өдөр хурлаар Эрчим хүчээр хангах хувилбар нь Мандалговь–Арвайхээр” чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 287 км ЦДАШ, дэд станц барьж “Арвайхээр–Хархорин” чиглэлийн 110 кВ-ын ЦДАШ-аар хангах бөгөөд тус хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлүүлсэн. ЭЗХЯ-ны шийдвэр хүлээгдэж байна. Эхний ээлжинд техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл хийгдсэн.<br>Багануур-Чингис-Чойбалсан, Багануур-Налайх-Сонгино, Сайншанд-Цагаансуварга, Дархан-Сонгино чиглэлийн шугамуудыг мөн Дэлхийн банк, ЕСБХБ-ны санхүүжилтээр үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ба МУ-ын өрийн таацаас шалтгаалан хэрэгжүүлэх хугацааг хойшлуулсан. Улаанбаатар хотод шинээр барих 110 кВ-ын дэд станцуудыг 2025 оноос санхүүжүүлэхээр Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан. 220 кВ-ын Оюут дэд станцыг Эрдэнэт үйлдвэр өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ба зураг төсөл хийгдсэн. | 70 |
| ***А.3. Эрчим хүчний нүүрс, хийн түлшний талаарх хууль тогтоомж, дүрэм, журмын төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 33 | **МУЗГҮАХ-6.2.9.** | ЗГҮАХХАХТ-6.2.9.8 Бүс нутгийн | Үйл ажиллагааны | - | Бодлогын дэмжлэг | Бүс нутгийн томоохон уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, бодлогын дэмжлэг үзүүлэх /5 газар/ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулна. Аймгийн төвүүдийн гэр хорооллын айл өрхүүдийг ухаалаг тоолуурт шилжүүлж, цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтийг үзүүлж, агаарын бохирдлыг бууруулна. | томоохон уурхайнуудыг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих ТЭЗҮ боловсруулах, бодлогын дэмжлэг үзүүлэх /5 газар/ | хэрэгжилтээр | | үзүүлсэн байна. | ажлын хүрээнд "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ-аас 7 байршилд ТЭЗҮ боловсруулж, ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн баталсан. ТЭЗҮ батлагдсантай холбогдуулан орон нутагт сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барьж байгуулах санхүүжилтийг шийдвэрлэх талаар Увс, Хөвсгөл, Булган, Дархан-Уул, Дорнод, Дорноговь аймаг, Багануур дүүргийн Засаг дарга нарт албан бичиг хүргүүлсэн.<br>Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулахаар шийдвэрлэсэн. "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ-ын боловсруулж ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2021.05.14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн ТЭЗҮ-ийг үндэслэн "Хөшөөтийн уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах /Ховд/" төсөл, арга хэмжээг улсын төсвийн 15,748.2 сая төгрөгөөр 2021-2024 онд хэрэгжүүлж байна. 2024 оны улсын төсөвт 6,311.9 сая төгрөг батлагдсан бөгөөд 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт санхүүжилт 82%, барилгын ажил 93%-тай байна. | |
| ***А.4. Сэргээгдэх эрчим хүчний талаарх бодлого, хууль тогтоомж, дүрэм, журмын төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 61 | **ТЭХТББББ-3.1.1.** Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангана. | Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг зохион байгуулах, удирдамжаар хангах тулгамдсан асуудлуудыг шийдвэрлүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Эрчим хүчний салбарын 2021-2022, 2022-2023, 2023-2024 онуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, өвлийн их ачааллыг хүндрэлгүй давах зорилгоор Эрчим хүчний сайдын тушаалаар жил бүр ажлын хэсэг байгуулан, төрийн, орон нутгийн болон хувийн өмчит 43 үйлдвэр, компаниудын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавин, өвөлжилтийн бэлтгэл ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг сар бүр нэгтгэн, удаашралтай хэрэгжиж буй ажлуудын талаар ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж, холбогдох үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, тулгамдаж буй асуудлын талаар Засгийн газрын хуралдаан, Улсын онцгой комиссын хуралдаанд тухай бүр танилцуулан, гарсан хүндрэлийг тухай бүр шуурхай зохицуулан ажиллалаа. Үүнд:<br>- 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд үйлдвэр, компаниудын их засвар болон улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмж, бараа материал хил гааль дээр саатсантай холбогдуулан УОК, ГХЯ болон холбогдох байгууллагуудтай хамтран хилээр яаралтай нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулан, шийдвэрлэсэн.<br>2023 онд өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд байгалын гэнэтийн гамшигт үзэгдлийн улмаас Булган аймгийн Гурванбулаг сум, Улаанбаатар хотод үүссэн аваар саатлыг хэвийн болгоход зарцуулсан нийт 2.4 тэрбум төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргуулж ЦДҮС ТӨХК-д 1796 сая төгрөг, УБЦТС ТӨХК-д 626.3 сая төгрөгөөр аваарын нөөцийг бүрдүүлсэн. | 100 |
| 62 | | Үйлдвэр, | Үйл ажиллагааны | - | Хэрэгжилт 100% | Эрчим хүчний салбарын 43 үйлдвэр, компаниудын их засвар, техникийн зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөг нэгтгэн, салбарын | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td>компаниудын их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын нэгдсэн төлөвлөгөөнд хяналт тавих, удирдамжаар хангах</td><td>хэрэгжилтээр</td><td></td><td></td><td>өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөг батлан, ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг сар бүр нэгтгэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.
<table>
<tr><th>Он</th><th>Их засварын ажлын нэр төрлийн тоо</th><th>ТЗБАХ-ний ажлын нэр төрлийн тоо</th><th>Хөрөнгө оруулалтын ажлын нэр төрлийн тоо</th><th>ӨБА-ын биелэлт</th></tr>
<tr><td>2021-2022 он</td><td>3699</td><td>5527</td><td>3213</td><td>96%</td></tr>
<tr><td>2022-2023 он</td><td>1103</td><td>388</td><td>610</td><td>96%</td></tr>
<tr><td>2023-2024 он</td><td>1172</td><td>426</td><td>606</td><td>98%</td></tr>
</table></td><td></td></tr>
<tr><td>63</td><td></td><td>Үйлдвэр, компаниудад эрчим хүчний байгууламж, тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн хэрэгжилтийг хангуулах</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</td><td>-</td><td>Хэрэгжилт 100%</td><td>2021 онд эрчим хүчний салбарын нийт 31 байгууллага түүний салбар, нэгжүүдийн нийт 616 удирдах ажилтан, албан хаагчдаас ААД, ТАД болон бусад холбогдох дүрмийн хүрээнд мэдлэгийн шалгалтыг зохион байгуулсан. Жил бүрийн бэлтгэл хангах ажлын хүрээнд үйлдвэр, компаниуд дээр эрчим хүчний байгууламж, тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн хэрэгжилтийг үзлэг шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна.</td><td>70</td></tr>
<tr><td>64</td><td rowspan="3">ТЭХТББХДХХ-3.19.1.<br>Нэгдсэн сүлжээ болон төвлөрсөн дулаан хангамжийн төлөвлөлт, горим, диспетчерийн нэгдсэн зохицуулалтын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ.</td><td>Эрчим хүчний нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн системүүдийн оновчтой горимыг төлөвлөх, мөрдүүлэх</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</td><td>-</td><td>Хэрэгжилт 100%</td><td>Жил бүр ТБНС, ББЭХС, ДБЭХС, АУЭХС, Өмнөд бүсийн зуны бага ачаалал, өвлийн их ачааллын горимыг эрчим хүчний салбарын ерөнхий инженерүүдийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэн батлуулж, мөрдөн ажиллаж байна. Мөн ДЦС-4 ТӨХК-ийн хэсэгчилсэн зогсолт, Дулааны цахилгаан станцууд дээр зуны их болон урсгал засварын ажилтай холбоотойгоор хийгдэх бүрэг болон хэсэгчилсэн зогсолт, Сонгууль, Улсын баяр наадам, Цагаан сар зэрэг тэмдэглэлт өдрүүдийн үеийн горимыг тухай бүр баталж мөрдөн ажиллаж байна.</td><td>100</td></tr>
<tr><td>65</td><td>Түгээх сүлжээний дунд хүчдлийн саармагжилтийг өөрчилж, газардсан саармагжилтийн горимд шилжүүлэх ажлыг судалгаанд тулгуурлан үе шаттайгаар хэрэгжүүлж, шугам тоноглолын аюулгүй ажиллагаа найдвартай байдлыг нэмэгдүүлэх</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</td><td>-</td><td>Хэрэгжилт 100%</td><td>Түгээх сүлжээний дунд хүчдэлийн тусгаарлагдсан саармагжилтыг өөрчлөх ажлын хүрээнд 35, 110 кВ-ын дэд станцуудад резистив газардуулга суурилуулах ажлыг судалгаанд тулгуурлан үе шаттай хэрэгжүүлэн шугам, тоноглолын найдвартай байдлыг ханган ажиллаж байна.<br>“УБЦТС” ТӨХК-ийн 35/10кВ-ын Нарлаг, Дорнод-1, Хагжил, Яргайт, Дашчойнхор дэд станцууд, 35/6 кВ-ын Дөрвөн зам, Эсгийлэх, Олимп, Цэлмэг, Ваар, Баянхошуу дэд станцууд болон ДЦС-3 ТӨХК-ийн 35 кВ-ын ИХБ-уудыг газардуулгын горимд шилжүүлэх ажлууд үе шаттайгаар хэрэгжсэн.</td><td>70</td></tr>
<tr><td>66</td><td>Реле хамгаалалт, автоматикийн байгууламжийн шинэчлэлтийн бодлого, нэг маягийн зураг схем боловсруулах, системийн тогтворжилтийн байдалд үнэлэлт</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</td><td>-</td><td>Хэрэгжилт 100%</td><td>“ДҮТ” ТӨХХК-иас WAMS системийг 39 цэгээр өргөтгөх, RTDS-ийг шинээр суурилуулах ажлын хүрээнд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу “Шилжилтийн горимын хяналт мэдээллийн WAMS системийг өргөтгөх (ДҮТ/202109039)” тоот тендерийг сонгох шалгаруулж, өргөтгөлийн ажлыг “РЗА” ХХК хийж гүйцэтгэсэн.</td><td>70</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөмж, удирдамжаар хангах | | | | | |
| 67 | **ТЭХТББХДХХ-3.17.2.** Улаанбаатар хот болон орон нутгийн түгээх сүлжээнд удирдлага, хяналт, мэдээллийн сисемийг нэвтрүүлнэ. | Хот суурин газрын цахилгаан түгээх сүлжээнд ухаалаг төхөөрөмж, тоолуур нэвтрүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | “Нийслэлийн гэр хорооллын айл өрхөд 4кВт-ын хүчин чадалтай 5012 айл өрхийг цахилгааны халаагуур ашиглах техникийн боломж бүрдүүлэх” төсөл арга хэмжээний нийт 12 багц барилга угсралтын ажил явагдаж байгаагаас 8 багц ажил бүрэн дууссан ба үлдсэн 4 багц ажлын гүйцэтгэл 94% явцтай байна.<br>-Багц-5 Улсын комисс ажиллах тухай Эрчим хүчний сайдын 2024.04.10-ны өдрийн А/94 тоот тушаал гарсан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 87% -Багц-6 Улсын комисс ажиллах тухай Эрчим хүчний сайдын 2024.04.10-ны өдрийн А/93 тоот тушаал гарсан. Барилга угсралтын гүйцэтгэл 87% -Багц-9 10 кВ-ын хүчний кабель татах ажил хийгдэж байгаа. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50% -Багц-12 Төслийн хүрээнд нийт 5619 ширхэг тоолуур, DCU маркийн датацонтентратор 60 ширхэгийг суурилуулсан. Эрчим хүчний сайдын А/103 тоот тушаалаар Улсын комисс 2024.05.29-ний өдөр ажилласан. Үүрэг даалгаврын биелэлт хангуулж байна. Барилга угсралтын гүйцэтгэл 100% | 90 |
| 68 | | Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн мэдээлэл, хяналтын системийн хүрээг өргөжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл”-ийн Бүрэлдэхүүн хэсэг-3 буюу “Шинэ техник технологи нэвтрүүлэх ажил”-ын хүрээнд 2 багц төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:<br>- Lot-3.1. Хэрэглэгчийн төлбөр тооцоонд ашиглах ухаалаг тоолуур суурилуулах ажил. Техникийн шаардлага, ажлын ээлхүүний өөрчлөлтийг төслийн зөвлөх компанитай хамтран бэлтгэж ЕСБХБ-наас 2024.05.15-ны өдөр зөвшөөрөл авсан. Ажлын зураг төсөв боловсруулах ажил хийгдэж байна.<br>Lot-3.2. Алсын зайн хяналт удирдлагын системтэй цахилгаан активатор бүхий бөмбөлгөн хаалт суурилуулах ажил. Эрчим хүчний яамнаас 2024.05.07-ны өдөр Ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авч ажлыг эхлүүлсэн. Ажлын явц 40 хувийг гүйцэтгэлтэй байна. | 50 |
| 69 | **ТЭХТББХДХХ-3.21.1.** Айл өрх албан байгууллагын дулаан, цахилгааны хэрэглээг 100 хувь хэмжүүрээр тооцдог болох, ухаалаг тоолуурыг үе шаттай нэвтрүүлнэ. | Аймгуудын төсөвт байгууллагуудыг дулааны эрчим хүчний тоолуураар тоолууржуулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Эрчим хүчний зохицуулах хорооноос дулааны эрчим хүчийг хэмжүүрээр тооцох үнэ тарифыг орон нутгуудад тогтоож баталж өгсөн. Тоолуур суурилуулах эсэх асуудал нь тухайн аймгуудын төсвийн захирагч нарын шийдэх асуудал тул хариуцсан чиг үүрэгт хамаарахгүй болно. | 0 |
| ***Б.3. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн найдвартай ажиллагаа, түүний ашиглалтын аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 70 | **Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль-5.3.1.** Сэргээгдэх эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ. | Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Дэлхийн банкны төслийн хүрээнд хэрэгжсэн Ховд аймгийн Мянгад сумын нутагт баригдсан 10 МВт-ын нарны цахилгаан станцыг 2022 оны 05-р сард, Азийн хөгжлийн банкны Завхан аймгийн Улиастай сумын нутагт баригдсан 5 МВт-ын нарны цахилгаан станц, 1.2 МВт, 3.6 МВт/ц-ын хуримтлуурын станцыг 2022 оны 11-р сард, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт баригдсан 10 МВт-ын нарны цахилгаан станцыг 2023 оны 12-р сард, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутагт баригдсан 15 МВт-ын нарны цахилгаан станцыг 2024 оны 06-р сард тус тус ашиглалтад оруулсан. Нийт 40 МВт-ын хүчинчадалтай нарны цахилгаан станцыг шинээр ашиглалтад оруулсан. | 100 |

<table>
<tr><td>71</td><td rowspan="2">Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль-5.3.5. Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн цахилгааны түгээх сүлжээнд нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах журмыг хэрэгжүүлнэ.</td><td>Бага оврын сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр бүхий хэрэглэгчийн үйлдвэрлэсэн цахилгааныг түгээх сүлжээнд нийлүүлэх харилцааг зохицуулах журмыг хэрэгжүүлэх</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</td><td>-</td><td>Хэрэгжилт 100%</td><td>2021 онд 8 хэрэглэгчийн 76.08 кВт, 2022 онд 10 хэрэглэгчийн 122.6 кВт, 2023 онд 22 хэрэглэгчийн 378.6 кВт, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 10 хэрэглэгчийн 212.6 кВт, нийт 69 хэрэглэгчийн 789.88 кВт-ын хүчин чадалтай бага оврын нарны цахилгаан үүсгүүрт техникийн нөхцөл олгож, түгээх сүлжээнд холбогдсон байна.</td><td>100</td></tr>
<tr><td>72</td><td>СЭХ-ний нөөцийн байнгын ажиллагаатай автомат, хэмжилтийн станц бүхий интернетэд суурилсан нэгдсэн мэдээлэл дамжуулах сүлжээ байгуулах</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</td><td>-</td><td>Хэрэгжилт 100%</td><td>Азийн хөгжлийн банкны “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд 40-200 м-ийн өндөрт хэмждэг SoDAR төхөөрөмж 2 ширхэг, 40м, 60м, 100м хэмждэг 3 ширхэг суурин салхины хэмжилтийн станцуудыг худалдан авч, 2021-2024 онуудад Увс аймгийн Өмнөговь, Наранбулаг сум, Завхан аймгийн Тэлмэн сум, Говь-Алтай аймгийн Тайшир, Халиун сум, Дундговь аймгийн Сайнцагаан сум, Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд салхины хэмжилтүүдийг хийж гүйцэтгэж байна.</td><td>50</td></tr>
<tr><td colspan="8">Б.4. Эрчим хүчний байгууламжийн аюулгүй байдлыг хангуулах болон эрчим хүчний барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулах, зохицуулах үндсэн чиг үүргийн хүрээнд:</td></tr>
<tr><td>73</td><td rowspan="2">Эрчим хүчний тухай хууль-6.1.13.<br>Эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулна.</td><td>Эрчим хүчний эх үүсвэр, цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ, дулааны шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажлуудыг ашиглалтад оруулах</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</td><td>-</td><td>Хэрэгжилт 100%</td><td>Улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан эх үүсвэр, цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ, дулааны шугам сүлжээний төсөл арга хэмжээний барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах, хүлээн авах ажлыг Эрчим хүчний сайдын 2019 оны 125 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам”-ын дагуу зохион байгуулж байгаа бөгөөд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагаас комисс томилуулах тухай хүсэлтийн дагуу материалын бүрдлийг хянаж, Техникийн комиссыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар, Улсын комиссыг Эрчим хүчний сайдын тушаалаар тус тус томилон ажиллуулж байна. 2021-2024 онуудад эх үүсвэр, цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ, дулааны шугам сүлжээний нийт 100 төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулан, улсын комиссоор хүлээн аваад байна.<br><table><tr><th>№</th><th>Он</th><th>Техникийн комисс</th><th>Улсын комисс</th></tr><tr><td>1</td><td>2021</td><td>29</td><td>26</td></tr><tr><td>2</td><td>2022</td><td>24</td><td>22</td></tr><tr><td>3</td><td>2023</td><td>18</td><td>34</td></tr><tr><td>4</td><td>2024</td><td>11</td><td>18</td></tr><tr><td>5</td><td>Нийт</td><td>82</td><td>100</td></tr></table></td><td>100</td></tr>
<tr><td>74</td><td>Орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах</td><td>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</td><td>-</td><td>Хэрэгжилт 100%</td><td>Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутагт баригдсан 15 МВт-ын нарны цахилгаан станцыг 2024 оны 06-р сард тус тус ашиглалтад оруулсан.</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 75 | **МУЗГҮАХ-3.5.7.** Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн орон нутагт хэрэгжүүлэх иргэний болон үйлдвэрлэлийн барилга байгууламжийн томоохон төслийн эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ, дэд бүтцийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг хийнэ. /Хөшигийн хөндийд баригдах бүтээн байгуулалттай холбоотой дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг судалж, үе шаттай хэрэгжүүлнэ/ | ЗГҮАХХАХТ-3.5.7.1, Хөшигийн хөндийд баригдах бүтээн байгуулалттай холбоотой дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг судалж, үе шаттай хэрэгжүүлэхэд салбарын оролцоог хангах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Салбарын оролцоог хангасан байна. | Хөшигийн хөндийд баригдах бүтээн байгуулалттай холбоотой дулаан, цахилгааны эх үүсвэрүүдийг судалж, үе шаттай хэрэгжүүлэхэд салбарын оролцоог хангах ажлын хүрээнд Эрчим хүчний сайдын 2020 оны 252 дугаар тушаалаар байгуулагдсан “Цахилгааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх ажлын хэсэг”-ийн 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцэж 111/2021/252 дугаартай техникийн нөхцөл олгосон.<br>“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл /Төв/ Багц-3:"Шинэ Зуунмод" хотын эхний ээлжийн Сонгино-Сэргэлэн 220 кВ-ийн 2 хэлхээт 76.8 км ЦДАШ /Төв, Сэргэлэн/ барилга угсралтын худалдан авах ажиллааг зарлаж шалгарсан байгууллагуудтай 2023 оны 05 дугаар сарын 31-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 31-ны өдөр хүртэлх ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажилсан бөгөөд дээрх ЦДАШ-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл нь дундажаар 60%-тай үргэлжилж байна.<br>“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл /Төв/ Багц-4:"Шинэ Зуунмод" хотын эхний ээлжийн 220/110/35кВ-ын 2*125 МВА чадалтай "Сэргэлэн" дэд станц, удирдлагын барилга угсралтын ажил /Төв, Сэргэлэн/-ын худалдан авах ажиллагааг зарлаж шалгарсан компанитай 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан бөгөөд дээрх дэд станцын барилга угсралтын ажил 33%-тай үргэлжилж байна. | 100 |
| 76 | | ЗГҮАХХАХТ-3.5.7.2, Олон улсын нисэх онгоцны буудал, Богдхан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр логистикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн судалгаа, эх үүсвэрийг тодорхойлж, зураг төслийг хийхэд салбарын оролцоог хангах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Салбарын оролцоог хангасан байна. | Эрчим хүчний сайдын 2020 оны 252 дугаар тушаалаар байгуулагдсан “Цахилгааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх ажлын хэсэг”-ийн 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцэж 01/2023/96 дугаартай техникийн нөхцөл олгосон. | 100 |
| 77 | **МУЗГҮАХ-3.5.7.** “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ хотуудын хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ. | ЗГҮАХХАХТ-3.5.7.1, “Шинэ Зуунмод” хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлэхэд салбарын оролцоог хангах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Салбарын оролцоог хангасан байна. | “Шинэ Зуунмод” хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлэхэд салбарын оролцоог хангах ажлын хүрээнд Эрчим хүчний сайдын 2020 оны 252 дугаар тушаалаар байгуулагдсан “Цахилгааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх ажлын хэсэг”-ийн 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцэж 111/2021/252 дугаартай техникийн нөхцөл олгосон.<br>"Шинэ Зуунмод" хотын эхний ээлжийн 110 кВ-ын 2 хэлхээт 9.8 км ЦДАШ, 2*40 МВА “Аэро сити” дэд станцын ИХБ-ын тоноглолын суурь, удирдлагын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Да хот” ХХК, “Илч хангай” ХХК -уудын түншлэл шалгарч барилга угсралтын ажил нь 50%-тай үргэлжилж байна.<br>2х16МВА чадалтай Хөшигт дэд станцаас 110кВ-ын 2 хэлхээт 10.4 км ЦДАШ-аар 2х25МВА чадалтай “Шинэ зуунмод” дэд станцыг холбох, 110/35/10кВ-ын 2х25 МВА чадалтай “Шинэ зуунмод” дэд станцыг барих, ИХБ-ын тоноглолын суурь, удирдлагын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Илч хангай” ХХК, “Саруул өргөө конштракшн” ХХК-уудын түншлэл шалгарч барилга угсралтын ажил нь 80%-тай үргэлжилж байна. | 100 |
| 78 | | ЗГҮАХХАХТ-3.5.7.2, “Майдар” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Салбарын оролцоог хангасан байна. | “Улаанбаатар хотын шинэ дагуул хотуудыг түшиглэн баригдах дулаан, цахилгааны эх үүсвэрийн ТЭЗҮ боловсруулах” зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг БХБЯ-наас зохион байгуулан “Мон-Энержи консалт” ХХК 2021-2022 онд гүйцэтгэж, ЭХЯ-ны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцэн дэмжсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлэхэд салбарын оролцоог хангах | | | | | |
| 79 | **МУЗГҮАХ-3.7.13.** Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ. | ЗГҮАХХАХТ-3.7.13.4, Налайх дүүрэгт байгуулах Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркын дэд бүтцийг барьж байгуулахад салбарын оролцоог хангах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Салбарын оролцоог хангасан байна. | Эрчим хүчний сайдын 2020 оны 252 дугаар тушаалаар байгуулагдсан “Цахилгааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх ажлын хэсэг”-ийн 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар хэлэлцэж 37/2023 дугаартай техникийн нөхцөл олгосон. | 100 |
| 80 | **МУЗГҮАХ-6.1.11**. Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. | ЗГҮАХХАХТ-6.1.11.1, "Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулахад салбарын оролцоог хангах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Салбарын оролцоог хангасан байна. | Эрчим хүчний сайдын 2020 оны 252 дугаар тушаалаар байгуулагдсан “Цахилгааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх ажлын хэсэг”-ийн 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар хэлэлцэж 11/2021/252 дугаартай техникийн нөхцөл олгосон. | 100 |
| 81 | | ЗГҮАХХАХТ-6.1.11.2, "Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Салбарын оролцоог хангасан байна. | Эрчим хүчний сайдын 2020 оны 252 дугаар тушаалаар байгуулагдсан “Цахилгааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх ажлын хэсэг”-ийн 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар хэлэлцэж 37/2023 дугаартай техникийн нөхцөл олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулахад салбарын оролцоог хангах | | | | | |
| 82 | | ЗГҮАХХАХТ-6.1.11.3, "Багануур үйлдвэрлэл технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулахад салбарын оролцоог хангах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Салбарын оролцоог хангасан байна. | Эрчим хүчний сайдын 2020 оны 252 дугаар тушаалаар байгуулагдсан “Цахилгааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх ажлын хэсэг”-ийн 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар хэлэлцэж 125/2022/252 дугаартай техникийн нөхцөл олгосон. | 100 |
| 83 | | ЗГҮАХХАХТ-6.1.11.4, "Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулахад салбарын оролцоог хангах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Салбарын оролцоог хангасан байна. | Эрчим хүчний сайдын 2020 оны 252 дугаар тушаалаар байгуулагдсан “Цахилгааны техникийн нөхцөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх ажлын хэсэг”-ийн 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцэж 110/2021/252 дугаартай техникийн нөхцөл олгосон. | 100 |
| В.ЭРЧИМ ХҮЧНИЙ НҮҮРСНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ, ТҮЛШ, ХИЙН АШИГЛАЛТЫГ НЭВТРҮҮЛЭХ ТАЛААРХ БОДЛОГО, ХУУЛЬ, ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОХИЦУУЛАХ ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| ***В.1. Эрчим хүчний нүүрс, хийн талаарх хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 84 | **Эрчим хүчний тухай хууль-6.1.2.** Анхдагч эрчим хүч, түлшний хангамжийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ. | Багануур ХК, Шивээ-Овоо ХК, Шарын гол ХК-уудын үйл ажиллагаанд хяналт тавьж, нэгдсэн удирдамжаар хангах, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Бодлогын дэмжлэг үзүүлсэн байна. | Эрчим хүчний нүүрс олборлогч уурхайнуудын нүүрс нийлүүлэлт болон үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаа явуулахад тулгамдаж байгаа асуудлыг судлан, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Эрчим хүчний үйлдвэрлэлд шаардагдах нүүрсний хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор “Багануур” ХК болон “Шивээ-Овоо” ХК-ийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулан бусад холбогдох материалын хамт а/1693 албан бичгээр ЗГХЭГ-Т хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын 2024 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.<br>Багануур ХК, Шивээ Овоо ХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хүндэрч, мөнгөн хөрөнгийн дутагдалд орж ихээхэн хэмжээний өр төлбөр үүсээд байгаа болон цаашид | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бодлогын дэмжлэг үзүүлэх | | | | өсөн нэмэгдэх нүүрсний хэрэглээтэй холбогдуулан Эрдэнэс Монгол ХХК-иас зохион байгуулан ЭХЯ, УУХҮЯ, ЭХЗХ, уурхай, станц, ЦУОШГ-ын удирдлагууд оролцсон хуралдаанд 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр оролцож уурхайнуудад тулгамдаад байгаа асуудлыг Эрдэнэс Монгол ХХК-ийн зүгээс Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлэхээр тогтов.<br>Эрчим хүчний нүүрсний хэрэглээний өсөлтөөс шалтгаалан нүүрс олборлогч уурхайнууд болон төвийн бүсийн дулааны цахилгаан станцуудын хооронд байгуулсан “Нүүрс худалдах, худалдан авах” гэрээнээс нэмэлтээр шаардагдах нүүрсний хангамэтай холбоотойгоор гарч буй хүндрэлтэй асуудлаар санал боловсруулан уурхайнуудад авах арга хэмжээний талаар а/1693 дугаар албан бичгийг ”Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлсэн.<br>Дулааны цахилгаан станц, дулааны станцуудын 2024 оны нүүрсний хэрэглээний тооцооллыг шинэчлэн, станцуудаас цахимаар авч нэгтгэн 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нүүрсний аюулгүйн нөөцийг бүрдүүлэх зорилгоор уурхайнуудын уулын ажлын төлөвлөгөөнд оруулах саналыг Засгийн газрын хуралдаанаар оруулж шийдвэрлүүлэхээр 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн а/1693 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж ажилласан.<br>2024 оны 01 дүгээр сард эрчим хүчний нүүрсний хэрэглээ оргил ачаалалдаа хүрсэнтэй холбогдуулан нүүрсний вагоноор уурхайнуудыг жигд ханган, нүүрсний тээврийг доголдолгүй явуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай албан бичгийг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр б/54 дугаартай, 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр б/464 дугаартай, 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр б/653 дугаартайгаар УБТЗ-д хүргүүлж ажилласан. Нүүрсний тээвэр, нүүрсний захиалга, ачилт буулгалт, вагон хангамжийн асуудлаар 2024 оны 1 дүгээр улиралд сар бүрийн 20-25-ны өдрүүдэд УБТЗ, уурхай, станцуудын удирдлагуудыг оролцуулан зохион байгуулсан цахим хуралдаанаар холбогдох албан тушаалтнуудад үүрэг, чиглэл өгч ажилласан. | |
| 85 | | Төвийн бүсийн дулааны цахилгаан станц, дулааны станцуудын нүүрсний хэрэглээг эрчим хүчний нүүрс олборлогч уурхайнуудын уулын ажлын төлөвлөгөөнд тусгуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Төвийн бүсийн дулааны цахилгаан станц, дулааны станцууд нь 2024 оны 01 дүгээр сард уурхайнуудтай нүүрс худалдах, худалдан авах гэрээг байгуулан ажиллаж байгаа ба станцуудын нүүрсний хэрэглээний тооцоо, судалгааг нэгтгэн гаргаж, нэмэлтээр шаардлагатай нүүрсний хэрэглээг нүүрсний уурхайнуудын уулын ажлын төлөвлөгөөнд тодотон тусгуулах саналыг уурхайнуудад хүргүүлэн ажиллаж байна. 2024 оны 1 дүгээр улирлын эрс хүйтрэлтээс шалтгаалан нэмэгдсэн эрчим хүчний нүүрсний хэрэглээний тооцооллыг гарган 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Багануурын уурхайд б/465, Шивээ Овоогийн уурхайд б/466 дугаартай албан бичгийг хүргүүлэв.<br>Эрчим хүчний нүүрсний хэрэглээний өсөлтөөс шалтгаалан нүүрс олборлогч уурхайнууд болон төвийн бүсийн дулааны цахилгаан станцуудын хооронд байгуулсан “Нүүрс худалдах, худалдан авах” гэрээнээс нэмэлтээр шаардагдах нүүрсний хангамжтай холбоотойгоор гарч буй хүндрэлтэй асуудлаар санал боловсруулан уурхайнуудад авах арга хэмжээний талаар а/1693 дугаар албан бичгийг” Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлсэн. | 100 |
| 86 | | Хувийн хэвшлийн нүүрсний уурхайнуудаас эрчим хүчний эх үүсвэрүүдэд нүүрс нийлүүлэх боломжийн талаар судалгаа, шинжилгээ хийх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Төвийн бүсийн дулааны цахилгаан станц, дулааны станцуудын эрчим хүчний нүүрсний эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх зорилгоор дэд бүтэц сайн хөгжсөн, уулын үйлдвэрлэл явагдаж хөрс хуулалтын ажил хийгдсэн эрчим хүчний нүүрсний уурхайнуудын талаар судалгаа хийж, нүүрс нийлүүлэх боломжийн талаар судалж байна.<br>Төв аймгийн Баян сумaнд байрлах “Монкоул петро майнинг” ХХК-ийн уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр ТБХЗГ-ын дарга И.Лувсанцэрэнгээр ахлуулсан “ДЦС-3” ТӨХК, “Амгалан ДС” ТӨХК-ийн удирдлагуудыг оролцуулсан ажлын хэсэг газар дээр нь очиж ажилласан ба 05 дугаар сарын 30-ны өдөр “ДЦС-3” ТӨХК, “ДЦС-2” ТӨХК, “Амгалан ДС” ТӨХК-ийн холбогдох мэргэжилтнүүд, “Монкоул петро майнин” ХХК-ийн менежер, талбайн инженертэй хамтран нүүрсний овоолгоос дээж авч тус станцуудад болон хөндлөнгийн лабораториудад өгч шинжилгээ хийлгэн дүгнэлт, зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна. | 100 |
| 87 | **МУЗГҮАХ-5.1.1.** Улаанбаатар хотын | ЗГҮАХХАХТ-5.1.1.4, Нийслэлийн зүүн | Гүйцэтгэлийн хувиар | 75% | Хэрэгжилт 100% | Нийслэлийн зүүн бүсэд баригдах сайжруулсан шахмал түлш үйлдвэрийн барилга угсралтын ажлыг 2020 оны 05 дугаар сард эхлүүлсэн бөгөөд Эрчим хүчний сайдын 2020 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. | бүсэд сайжруулсан түлшний үйлдвэрийг барьж байгуулах | | | | оны А/141 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг үйлдвэрийн барилга угсралтын ажилд хяналт тавих, хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, удаашралтай байгаа ажлыг эрчимжүүлэх зорилгоор үйлдвэрийн газар дээр тогтмол ажиллаж барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажилд байнгын хяналт тавин үйлдвэрийг 2020.12.08-ны өдөр ашиглалтад оруулсан. | |
| 88 | **МУЗГҮАХ-6.2.9.** Орон нутгийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулна. | Бүс нутгийн томоохон уурхайнуудыг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих | Ашиглалтад орох үйлдвэрийн тоо | 0 | Орон нутагт 1-ээс доошгүй үйлдвэр ашиглалтад орсон байна. | Бүс нутгийн уурхайнуудыг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих ажлын хүрээнд Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэн баригдаж байгаа сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн барилга угсралтын ажилд хяналт тавьж байна. Төслийн ажил 90%-ийн гүйцэтгэлтэй байна. Үйлдвэр ашиглалтад орохтой холбогдуулан үйлдвэрийг орон нутагт хүлээлгэн өгөх зорилгоор Ховд аймгийн Засаг даргатай уулзалт зохион байгуулахаар ажиллаж байна. | 90 |
| ***В.2. Дулааны цахилгаан станц, дулааны станцуудын нүүрс болон сайжруулсан шахмал түлшний найдвартай хангамжийн талаар санал зөвлөмж боловсруулах, баланс гаргах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, арга зүйн удирдамжаар хангаж ажиллах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 89 | **ТЭХТББББ-3.1.** Эрчим хүчний салбарын түлшний хангамжийн найдвартай ажиллагааг хангана. | Дулааны цахилгаан станц, дулааны станцын жилийн нүүрсний хэрэгцээ, уурхайнуудын нүүрс олборлолт, нийлүүлэлт, хэрэглээний баланс, хэтийн төлөв, өсөлтийн хувь хэмжээг тодорхойлох | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Эрчим хүчний шинээр баригдах эх үүсвэр, дулааны цахилгаан станц, дулааны станцуудын өргөтгөл шинэчлэлтийн ажилтай уялдуулан эрчим хүчний нүүрсний хэрэглээний судалгааг гарган, 2030 он хүртэлх хэтийн төлөв, өсөлт бууралтын хувь хэмжээний тооцоо судалгаа хийж удирдлагад танилцуулав.<br>Эрчим хүчний нүүрсний 2018-2024 оны хэрэглээний судалгааг гарган, 2024-2028 оны нүүрсний хэрэглээний хэтийн төлөвийн тооцоолол, өсөлтийн хувь хэмжээг тодорхойлон, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаж байна.<br>Эрчим хүчний нүүрс олборлогч уурхайнуудын нүүрсний олборлолт, нийлүүлэлтийг сар бүрээр гарган, 2024 оны эхэнд хийсэн гэрээтэй уялдуулан өсөлт, бууралтын хэмжээг тодорхойлон удирдлагыг мэдээллээр хангаж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар төвийн бүсийн Багануур, Шивээ Овоо, Шарын голын уурхайнууд 4,315.2 мян.тн нүүрс олборлож, төлөвлөгөөний биелэлт 103%-ийн гүйцэтгэлтэй байна. Төвийн бүсийн дулааны цахилгаан станц, дулааны станцууд нь 3,829.0 мян.тн нүүрс авахаас 3,884.0 мян.тн нүүрс авч гүйцэтгэл 101.4%-ийн биелэлттэй байна. | 70 |
| 90 | | Нүүрсний уурхайнуудын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, нэгдсэн удирдамжаар хангах | Тогтоолын хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК, "Шарын гол" ХК, "Найнги" ХХК, "Адуунчулуун" ХК зэрэг нүүрсний уурхайнуудын их засвар, техникийн зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөө зэрэг ажлын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 5-ны өдрийн дотор хүлээн авч хяналт тавин ажиллаж байна.<br>"Багануур" ХК, "Шивээ Овоо" ХК, "Шарын гол" ХК, "Таван толгой түлш" ХХК нь 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 143 ажил төлөвлөсөн бөгөөд өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг нэгтгэн ЭХЯ-ны ЭХБХЗГ-т хүргүүлэн Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын нэгдсэн төлөвлөгөөнд нэгтгэсэн. | 100 |
| 91 | | Дулааны цахилгаан станцуудын өвлийн их ачааллын нөөцийг бүрдүүлэх хуваарийг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамжаар хангах | Төлөвлөгөө-ний хувиар | 10% | Өвлийн их ачааллын үеийн 14 хоногийн нөөц бүрдсэн байх | Эрчим хүчний салбарын үйлдвэр компаниудын 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд төвийн бүсийн дулааны цахилгаан станц болон дулааны станцуудын өвлийн их ачааллын нүүрсний нөөцийг 15-20 хоногоос доошгүй байхаар бүрдүүлэх хуваарийг боловсруулахад дулааны цахилгаан станцууд болон дулааны станцуудаас ирүүлсэн тооцооллыг Эрчим хүчний сайдын 2019 оны 158 дугаар тушаалаар баталсан "Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэх тохиолдолд Түлш, эрчим хүчний хангамжийн талаар мөрдөх журам"-ын хүрээнд хянасан. Тооцооллыг хянахад зарим станцуудын нүүрсний нөөц ӨБА-ыг хангах хугацаанд 15-20 хоногт хүрэхээргүй байсан тул зохицуулалт хийсний дагуу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 92 | | | | | | нүүрс нөөцлөлтийн төлөвлөгөөг боловсруулж 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Дэд сайдаар батлуулж ажилласан.<br>2024-2025 оны халаалтын улирлын нүүрс нөөцлөлтийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд станц тус бүрээр халаалтын улиралд хэрэглэгдэх нүүрсний хэрэглээний тооцоог ирүүлэх тухай 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн б/1054 тоот албан бичиг хүргүүлэн ирсэн саналуудад тулгуурлан “ДҮТ” ТӨХХК-аас 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 02/487 дугаар албан бичгээр ирүүлсэн ДЦС, ДС-уудын 2022-2023 оны өвлийн ачааллын хоногийн хамгийн их зарцуулалтыг үндэслэн нүүрс нөөцлөлтийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулсан.<br>Нүүрс нөөцлөлтийн төлөвлөгөөг дулааны цахилгаан станцууд болон дулааны станцуудад 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн б/1530 тоот бичгээр, УБТЗ ХНН-д б/1529 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. | |
| 92 | | Орон нутгийн дулааны станцууд болон халаалтын зуухны нүүрсний хангамжийг сайжруулах асуудлаар судалгаа хийж, санал боловсруулан зохицуулалтын арга хэмжээ авах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Орон нутгийн дулааны станцууд болон томоохон суурин газруудад нүүрс нийлүүлж байгаа эрчим хүчний нүүрс олборлогч уурхайнуудын судалгаа болон 2018-2023 оны нүүрс нийлүүлэлтийн судалгааг гарган удирдлагад танилцуулсан. Орон нутгийн чанартай уурхайнуудын 2024 оны нүүрс нийлүүлэлтийн төлөвлөгөөг нэгтгэн гаргасан ба 13 уурхай нийт эрчим хүчний нүүрсний хэрэглээний 12 хувийг бүрдүүлж байна.<br>Хөвсгөл, Завхан аймгийн иргэд, аж ахуйн нэгжид нүүрс нийлүүлэгч орон нутгийн өмчит “Могойн гол” ХК-ийн нүүрсний чанар муу байгаагаас шалтгаалан өвөлжилт хүндэрсэн тул 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн а/427 тоот албан бичгээр нүүрсний чанарыг сайжруулах, нүүрсний нийлүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймгийн засаг дарга, Хөвсгөл аймгийн ИТХ-д хүргүүлж ажилласан.<br>Хэнтий аймгийн “Хэнтий Ус” ОНӨААТҮГ нь нүүрсний нөөцгүй болж, өвөлжилт хүндэрсэн тухай 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр утсаар холбогдож мэдээлсний дагуу “Багануур” ХК-тай шуурхай холбогдон нүүрсний ачилтыг авто тээврээр хийх зохион байгуулалтыг авч ажилласан.<br>Булган аймгийн “Энержи плас” ХХК-иас эрс хүйтэрсэнтэй холбогдуулан нүүрсний нөөц багассан тул нүүрсний нийлүүлэлтийг 1,300 тн-р нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай албан бичгийг 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр 06 дугаартай ирүүлсэн тул “Шивээ Овоо” ХК-тай утсаар шуурхай холбогдож 02 дугаар сарын 23-ны өдөр 20 вагон нүүрс нийлүүлэх зохион байгуулалтыг авч ажилласан. | 100 |
| ***В.3. Хийн түлшний хангамжийн сүлжээ байгуулах, ашиглах талаар бодлогын хэрэгжилтийг зохицуулах, арга зүйн зөвлөгөө, удирдамжаар хангах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 93 | **МУЗГҮАХ-3.5.4.3.** Нүүрсний ордуудын метан хийн хангамжийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулна. | Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлж буй “Метан хийн хангамжийн сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах | Мастер төлөвлөгөө боловсруулах явц, хувиар | 10% | Хэрэгжилт 100% | Метан хийн хангамжийн сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр эцсийн байдлаар ирүүлсэн. Төслийн зөвлөх мастер төлөвлөгөөний ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн хийсэн эсэхэд хяналт тавьж, мастер төлөвлөөнд тусгагдсан ажлуудын талаар танилцуулга боловсруулан удирдлагад танилцуулж, хүлээн авсан. | 100 |
| 94 | | ТЭХТББХДХХ-3.1.5, Метан хийн хангамжийн норм, дүрэм, стандарт боловсруулах | Гүйцэтгэлийн хувиар | - | Батлагдсан төсвийн хүрээнд ажил хийгдсэн байна. | Мастер төлөвлөгөөний тайланд тусгагдсан эрх зүйн орчныг сайжруулах зөвлөмж болон Япон Улсын ЖАЙКА-ийн Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхийг бэхжүүлэх төслийн хүрээнд боловсруулсан “Хийн түлштэй холбоотой аюулгүй байдлын удирдамж”-д тусгасан зөвлөмжийг харьцуулан хийн түлшний эрх зүйн орчныг сайжруулах талаар харьцуулсан судалгаа хийж байна. | 30 |
| Г.ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТ ХИЙХ, ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАХ ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| ***Г.1.Бодлогын зорилго, зорилт, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, үр нөлөөг үнэлэх, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 95 | **Хөгжлийн** | Улсын хэмжээнд | Үйл | - | Хэрэгжилт | УИХ, Засгийн газраас баталсан Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль-9.6.** Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлнэ. | хэрэгжих урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, бодлогын зорилтын үр дүн, үр нөлөөг үнэлэх, бодлогын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх | ажиллагааны хэрэгжилтээр | | 100% | бодлогын баримт бичгүүдэд эрчим хүчний салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2022 оны жилийн эцэс, 2023 оны эхний хагас жилийн байдлаарх хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг яамны удирдлагуудад танилцуулан журамд заасны дагуу албан бичгээр болон цахим системээр ЗГХЭГ, ЭЗХЯ, Сангийн яаманд тус тус тайлагнасан.<br>ЗГХЭГ, ЗГХХГ-аас хийсэн ХШҮ-ний тайлан, зөвлөмж, ҮАГ-аас хийсэн гүйцэтгэлийн аудитын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, түүний биелэлтийг хугацаанд нь тайлагнаж ажиллав. | |
| 96 | | Эрчим хүчний салбарын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, бодлогын зорилтын үр дүнг үнэлэх, бодлогын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого “Алсын хараа-2050”, дунд хугацааны бодлого “МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд ХШҮ хийж, ЗГ-ын 2020 оны 2026 дугаар тогтоолоор баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журамд заасан хугацаанд багтаан ЗГХХГ, СЯ, ЭЗХЯ-нд тус тус тайлагнаж ажилласан. | 100 |
| 97 | **Хууль тогтоомжийн тухай хууль-50 дугаар зүйл.** Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг тооцож, мэдээлнэ. | Эрчим хүчний салбарт хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх, хэрэгжилтийн талаарх мэдээллээр тасралтгүй хангах үйл ажиллагаа хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Монгол Улсын хууль, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавраар эрчим хүчний сайд, эрчим хүчний яаманд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөн, ЗГХЭГ, ЗГХХГ-т тус тус холбогдох журамд заасны дагуу тайлагнаж ажиллав. | 100 |
| ***Г.2.Салбарын эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 98 | **Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол. “Дотоод аудитын дүрэм”.**<br>Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, салбарын байгууллагуудын хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө | Санхүү, төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хэрэгжүүлэх, хяналт шалгалт, дотоод аудитын үр дүнгээр салбарын эрсдэлийн түвшинг үнэлэх ажлыг нэгдсэн бодлого, арга зүй, зохион | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Засгийн газрын тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2015 оны “Дотоод аудитын дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоол, Сангийн сайдын 2013 оны “Дотоод аудитын хорооны дүрэм батлах тухай” 29 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Эрчим хүчний Сайдын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг баталсан. Дотоод аудитын хорооны даргаар Эрчим хүчний сайд, гишүүдэд төсвийн шууд захирагч-Төрийн нарийн бичгийн дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Гэрээ эрх зүйн газрын дарга, Төрийн бус байгууллагаас хараат бус 2 гишүүнийг оролцуулан нийт 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.<br>Жил бүр Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны тогтоолоор тухайн жилийн дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөнд тусгагдсан санхүүгийн, гүйцэтгэлийн аудитыг 100% гүйцэтгэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. | байгуулалтаар хангах | | | | | |
| 99 | | Салбарын онцлогийг тусгасан дотоод аудиттай холбоотой журам, заавар, гарын авлагыг боловсруулж, салбарын хэмжээнд дотоод аудитын нэгдсэн удирамжаар хангах ажлыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Эрчим хүчний яамны 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд "... салбарын онцлогийг тусгасан дотоод аудиттай холбоотой журам, заавар, гарын авлага боловсруулж, салбарын хэмжээнд дотоод аудитын нэгдсэн удирдамжаар хангах" гэж тусгагдсан ажлын хүрээнд төрийн өмчит компаниудад 2023.03.10-ны өдрийн 6/717 тоот албан бичгээр гарын авлагад тусгах санал ирүүлэхээр хүргүүлсэн. Тоотын хариуг 20 компаниас ирүүлснийг судалж, саналыг багцалж нэгтгэсэн. Гарын авлагын бүтэц, агуулгыг хэлэлцэж тодорхойлсон бөгөөд судалгаа, боловсруулалтыг хийж аргачлалын төслийг боловсруулж батлуулсан. | 100 |
| 100 | **Шилэн дансны тухай хууль-8.2.** Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавина. | Эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх, хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах | Салбарын хэмжээн дэх хуулийн хэрэгжилтийн дундаж хувь | - | 95-аас дээш | Сайдын 2024.01.17-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар 2023 оны жилийн эцсийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын дүн, зөвлөмжийг Дотоод аудитын хорооны 2023.03.01-ний өдрийн 24/02 дугаар тогтоолоор баталгаажуулав. ТНБД-ын 2024.03.05-ны өдрийн в/662 тоот албан бичгээр Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг даалгаврыг салбарын харъяа 40 байгууллагуудад хүргүүлэв.<br>Сангийн яамнаас жил бүр Төсвийн ерөнхийлөн захирагч нарын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийж, үнэлгээ өгдөг. Энэ хүрээнд Эрчим хүчний салбарт Шилэн дансны хуулийн хэрэгжилт 2021-2023 онд дунджаар 98%-тай үнэлэгдсэн. | 100 |
| ***Г.3.Эрчим хүчний салбарын аюулгүй байдлыг хангах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 101 | **ТЭХТББ-3.1.1.** Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангана. | Эрчим хүчний салбарт хүний болон технологийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн бодлого, удирдамжаар хангах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 6.1, 6.2 дахь заалт, Салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийг Нийслэл, орон нутгийн байцаагч нарт хүргүүлж удирдамжаар ханган ажилласан. | 70 |
| 102 | | Салбарын хөдөлмөрийн аюулгүй байдалд дүн шинжилгээ хийх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих, хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | 2023 оноос 2024 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд Салбарын үйлдвэр компаниудад 10 осол гарсныг судлан бүртгэж осол гарсан шалтгаан нөхцөлийг тодорхойлж тухай бүр компаниудад мэдээлэл-даалгаврыг боловсруулан биелэлтийг хангуулж ажилласан. Жил бүр цаг агаарын байдалтай холбогдуулж осол гарахаас урьдчилан сэргийлж ажиллах сэрэмжлүүлэг мэдээг компаниудад хүргүүлсэн. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх зардлыг тодорхой хэмжээнд төлөвлөн хасахгүй байхыг компаниудад албан бичгээр хүргэж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. | 70 |
| 103 | | Эрчим хүчний байгууламжийн | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Засгийн газрын 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 2.7-д "Хяналт шалгалтын байгууллага энэ журмын 2.5-д заасан шалгуур үзүүлэлтээр хяналт шалгалтын объектын эрсдэлийн ангилалд хамааруулах | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | техникийн аюулгүй байдалд дүн шинжилгээ хийх, технологийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх | | | | үнэлгээг тухайн хяналт шалгалтын чиглэлд хамаарах обьектод 2 жил тутам нэгээс доошгүй удаа хийнэ." Энэ журмын 2.8-д "Энэ журмын 2.7-д заасан эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалт, шалгалтад хамруулах давтамжийн хугацааг Засгийн газрын гишүүн батална" заалтын хүрээнд хяналт шалгалтын удирдамжийг боловсруулан батлуулж нийслэл орон нутгийн байцаагч нарт хүргүүлэн ажилласан. | |
| ***Г.4.Гамшгаас хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 104 | **Гамшгаас хамгаалах тухай хууль-33 дугаар зүйл.** Гамшгаас хамгаалах Улсын албаны чиг үүргийг хэрэгжүүлнэ. | Гамшгаас хамгаалах Түлш, эрчим хүчний Улсын албаны үйл ажиллагааг зохион байгуулах, гамшгийн үед салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | 100% | Эрчим хүчний сайдын 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 219 дугаар тушаал, 2023 оны 12 дугаар сарын 11-ний А/289 тоот тушаалаар Гамшгаас хамгаалах удирдлагын бүрэлдэхүүнийг тус тус шинэчилэн байгуулсан.<br>**2020 онд** Монгол улсад коронавирусТ халдвар /Ковид-19/-ын тохиолдол батлагдсантай холбогдуулж улсын албаны штаб нь гамшгийн үед салбарыг нэгдсэн удирдлага чиглэлээр ханган ажилласан.<br>**2020, 2021 онд** улсын хэмжээнд бэлэн байдалд шилжсэн үед штабын хурлыг тухай бүр зарлан салбарын үйлдвэр компаниудад үүрэг даалгаврыг хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан.<br>Салбарын үйлдвэр компаниудаас халдварын мэдээг цахим систем ашиглан авч 7 хоног бүр шинэчлэн УОК-ын шуурхай штабт хүргүүлж ажилласан. Мөн ковид-19-ын халдвартай холбоотойгоор эрчим хүчний салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, үйлдвэр компаниудын их, урсгал засварын сэлбэг материалыг импортоор татан авах ажил удааширсан тул ГХЯ, УОК-ын шуурхай штаб зэрэг байгууллагуудад тухай бүр хүсэлтийг уламжилж тээвэрлэлтийн ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан. Салбарын албан хаагчдыг вакцинжуулалтад хамруулах, ээлжийн ажилтнуудыг саадгүй зохицуулах зэрэг бусад шаардлагатай зохион байгуулалтыг тухай бүр хийсэн.<br>**2024 онд**<br>Өвөлжилт, хаваржилтыг хохирол багатай даван туулах, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, үүссэн үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын алба, яам, агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, удирдлага зохицуулалтаар хангах зорилгоор Улсын онцгой комиссын "Шуурхай штаб"-ыг 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 7 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд Түлш, эрчим хүчний гамшгийн улсын албанаас "Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндрэх нөхцөлд хийгдэх хариу арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө"-г ирүүлэх тухай 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 7/3869 тоот албан бичгийг салбарын үйлдвэр компаниудад хүргүүлж, ирүүлсэн төлөвлөгөөг нэгтгэн 2024 оны 01 сарын 05ны өдөр УОК-ийн Шуурхай штабын удирдлагад танилцуулж, мэдээллийн санд байршуулан ажилласан.<br>УОК-ийн Шуурхай штабаас 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдалтай газар дээр нь танилцахтай холбогдуулан Эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй асуудлын талаарх мэдээллийг ирүүлэх талаар албан бичгийг 2024.01.16-ны өдрийн в/155 тоот албан бичгээр хүргүүлж, хариуг нэгтгэн Шуурхай штабын удирдлагад танилцуулж, мэдээллээр ханган ажилласан.<br>Цаг агаар дулаарч нийт нутгийн цас мөс хайлж, хөрсний ус, булаг гарч, халиа дошин үүсч, шар усны үерийн улмаас эрчим хүчний барига байгууламж, шугам тоноглолд гэмтэл саатал гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах төлөвлөгөөг ирүүлэх талаар албан бичгийг 2024.03.20-ны в/816 тоотоор хүргүүлж, хариуг нэгтгэн боловсруулж, удирдлагад танилцуулсан.<br>Зуны улирал эхэлж байгаатай холбогдуулан бороо, хур тунадасны хэмжээ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэгдсэнээр үүсэх үер, ус, байгалийн болзошгүй аюул эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулах, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай тул зуны улирлын тойм мэдээ, хур тунадас /нийт тунадас, хамгийн их, бага/-ний хэмжээ, температур, салхины хурд зэрэг үзүүлэлтүүдийн олон жилийн дундаж мэдээ ирүүлэх тухай албан бичгийг Цаг уур, орчны шинжилгээний газарт 2024.06.04-ний өдөр явуулсан. Цаг уур, орчны шинжилгээний газраас 2024.06.11-ний 01/527 тоотоор хариуг ирүүлсэн бөгөөд салбарын үйлдвэр компаниудад сэрэмжлүүлэг хүргүүлэхээр 2024.06.20 ны өдөр" Арга хэмжээ авч ажиллах тухай" в/1940 албан тоот явуулсан. | |
| 105 | | Салбарын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, уялдаа, нэгдсэн удирдлагаар хангах | Төлөвлөгөөний дагуу ажлыг зохион байгуулах явц, хувиар | - | 100% | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн аюулын дуут дохиогоор ажиллах дадлага сургалтыг зохион байгуулах тухай Төрийн нарийн бичгийн даргын 2022.03.22-ны өдрийн в/1136 тоот албан бичгээр салбарын үйлдвэр, компаниудад хүргүүлсэн.<br>Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн ажиллах 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд саналаа 2023.12.17-ны өдрийн б/4310 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>"Газар хөдлөлтийн аюулын тухай" ерөнхий ойлголт, Дэлхийн болон Монгол Улсын газар хөдлөлтийн идэвхжил, төлөв байдал, газар хөдлөлтийн гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, газар хөдлөлтийн дадлага сургуулиар ажиллах үеийн зохион байгуулалт зэрэг чиглэлээр танхимын сургалтыг зохион байгуулсан бөгөөд ОБЕГ-тай жил бүр хамтран зохион байгуулдаг газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үед хэрхэн аюул ослоос өөрийгөө болон бусдыг хамгаалах, хор хөнөөл учирсан үед хэрхэн ажиллах, дадлага сургуулилтыг Эрчим хүчний яам, ДҮТ, ЭХҮТ-ийн нийт 183 алба хаагчдыг хамруулан 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 15:00 цагаас 15:50 цагийн хооронд амжилттай зохион байгуулсан.<br>Эрчим хүчний салбарын цахилгаан түгээх, дулаан, цахилгаан дамжуулах сүлжээнд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах төсөв мөнгийг хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллах тухай сайдын 2022.11.11-ний а/4347 тоот албан бичгээр эрчим хүчний салбарын ТӨХК-иудын ТУЗ, гүйцэтгэх захирал нарт хүргүүлсэн. 2023 онд ЦДҮС ТӨХК, ДБЭХС ТӨХК эрсдэлийн үнэлгээг хийлгэсэн байна.<br>Улсын онцгой комиссын даргын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн "Шуурхай бүлэг байгуулах тухай" 7 дугаар тушаалын дагуу 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндрэх төлөвтэй байгаа тул цаг агаарын аюулт үзэгдэл, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, аймаг, нийслэлийн Онцгой комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, Улсын онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах үүргийн дагуу өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндрэх нөхцөлд хийгдэх хариу арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн дотор ирүүлэхийг салбарын үйлдвэр, компаниудад Салбарын хяналтын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ний өдрийн 7/3869 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Уг албан бичгийн дагуу нийт салбарын 26 компани нарийвчилсан төлөвлөгөөг ирүүлсэн бөгөөд төлөвлөгөөг нэгтгэж 2024.01.10-ны өдөр Улсын онцгой комиссын ажлын хэсгийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.<br>ОХУ-ын "СО-ЕЭС" хувьцаат нийгэмлэгийн салбар Бурядын РДУ-аас Селендум-Дарханы 257, 258 ЦДАШ урсах чадлын дээд хэмжээг 150 Мвт-аас илүү гарахгүй хязгаарлах нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан Эрчим хүчний салбарыг Сайдын А/292 тоот тушаалаар 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн.<br>Эрчим хүчний хангамжийн тасралтгүй найдвартай байдалд байнгын хяналт тавьж, шаардлагатай үед зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах Гамшгаас хамгаалах Түлш, эрчим хүчний Улсын алба (штаб-ны) хариуцлагатай жижүүрийн хуваарийг Төрийн нарийн бичгийн даргын 2023.12.13-ны А/205 дугаар тушаалаар батласан бөгөөд, УОК-ийн Шуурхай Штабыг 2023.12.13-2024.05.15 хүртэл салбарын мэдээллээр хангах, шаардагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 106 | | Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэх тохиолдолд эрчим хүчний хангамжийн талаар мөрдөх журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах | Журмын хэрэгжилт, хувиар | - | 100% | Жил бүр үйлдвэр компаниудын аюулгүйн нөөцийн жагсаалтыг нэгтгэн гаргаж нөхөн хангалт, зарцуулалтад хяналт тавин ажиллаж байна.<br>“Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэх тохиолдолд түлш, эрчим хүчний хангамжийн талаар мөрдөх журам”-ын 6.2-т заасны дагуу компаниудын 2023 оны аюулгүйн нөөцийн зарцуулалт, нөхөн хангалт, хадгалалт, тооллого хийсэн ажлын тайланг ирүүлэх талаар салбарын 27 компанид Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн в/1674 тоот албан бичгийг хүргүүлсэн бөгөөд нийт 20 компаниас ирүүлсэн тайланг нэгтгэж, илтгэх хуудсаар газрын даргад танилцуулан ажилласан. | 70 |
| **ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ:** | | | | | | | |
| Д. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| ***Д.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үндсэн үүрэг хүлээж, төрийн захиргааны болон салбарын хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, аппаратад дотоод дэмжлэг үзүүлж удирдлага, ажилтнуудыг ажиллах хэвийн нөхцлөөр хангах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 107 | **Эрчим хүчний тухай хууль-6.1.10.** Эрчим хүчний салбарын хүний нөөцийн бодлогыг боловсруулна. | Эрчим хүчний салбарын хүний нөөцийн бодлогын бичиг баримт боловсруулж, батлуулах | Бодлогын баримт бичгийг боловсруулах ажлын явц, хувиар | 10% | Бодлогын баримт бичиг батлагдсан байна. | Эрчим хүчний сайдын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 68 дугаар тушаалаар 2020 оныг “Хүний нөөцийн хөгжлийг дэмжих” жил болгон зарлаж, салбарын хэмжээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг батлуулсан. Энэ ажлын хүрээнд “Эрчим хүчний салбарын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг батлуулж, хэрэгжүүлэхээр ажилласан бөгөөд “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ дээр нэгтгэн зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-д Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч, төсөлд тусгадаг байх гэж заасны дагуу салбарын онцлогт нийцсэн стратегийн хөтөлбөр, хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, заавриг боловсруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхжуулах чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахаар төлөвлөсөн. Хамтран ажиллах байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулан сонгож ажиллахаар ажлыг эхлүүлж байсан. Мөн хуулийн дагуу ирүүлсэн мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг 2020 оны байгууллагын төсөвт тусгасан боловч Дэлхий нийтээр тархсан шинэ төрлийн коронавирус цар тахлын улмаас Монгол улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгө, концессын гэрээ, буцалтгүй зээл тусламжаар хэрэгжих томоохон төсөл хөтөлбөрүүд зогсож, байгууллагын орлого буурч, санхүүгийн хувьд хүндрэл үүссэн тул “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ уг ажлыг зогсоосон тухай албан бичиг ирүүлсэн бөгөөд дээрх ажил түр зогсоод байна.<br>Эрчим хүчний салбарын хүний нөөцийн бодлогын бичиг баримт боловсруулах ажлыг гүйцэтгэхэд холбогдох төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээчдийн багийг ажиллуулахад Төрийн хэмнэлтийн хуулийн тухай хууль 2022 онд хэрэгжиж шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх боломжгүй өнөөдрийг хүрсэн. | 0 |
| 108 | | Шинээр барих эх үүсвэрийн мега төслүүд, ашиглалтын өмнөх захиргаанд ажиллах боловсон хүчнийг бэлтгэх асуудлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах | ТЭЗҮ-д заагдсан ажиллах боловсон хүчнийг сургах явц | - | Боловсон хүчин бэлтгэгдсэн байна. | Эрчим хүчний салбарын байгууллагуудын хүний нөөцийн судалгааг 2022-2024 онд жил бүр шинэчлэн гаргасан. Салбарын үйлдвэр, компаниудын 2021-2022, 2023 оны ажиллагсдын шилжилт хөдөлгөөний талаарх хүний нөөцийн нөхцөл байдлын судалгааг авч, дүн шинжилгээ хийсэн. Салбарын 27 байгууллагын **12800** ажиллагсдаас эрэгтэй 9600 буюу 73%, эмэгтэй 3200 буюу 27% үүнээс 2023 онд дунджаар нийт **12800** ажиллагдсын 21% нь тус тус шилжилт хөдөлгөөнтэй байна.<br>Эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл, арга хэмжээний хүрээнд шинээр бий болох ажлын байранд шаардагдах мэргэжилтний мэдээлэл, хүний нөөцийн судалгааг 2022, 2023, 2024 оны байдлаар гаргаж холбогдох БШУЯ болон ХНХЯ-нд хүргүүлсэн.<br>Эрчим хүчний салбарын төсөл, арга хэмжээний хүрээнд шинээр бий болох ажлын байранд | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шаардагдах мэргэжилтэй ажилтны мэдээлэл, судалгааг гаргасан. Хэрэгжиж буй **11** төсөл хөтөлбөрийн нэгжийн тус бүрээр нарийвчлан гаргаж нэгтгэсэн. Энэхүү төсөл, хөтөлбөрүүдэд нийт шаардагдах ажлын байр **12669,** үүнээс 2021-2025 онуудад бүтээн байгуулалтын үед бий болох ажлын байр **10648,** 2026-2030 онуудад ашиглалтанд орсноос хойш шинээр бий болох шууд ба шууд бус **2021** шаардлагатай байгааг мэргэжил тус бүрээр нарийвчлан гаргаж нэгтгэсэн. Мөн ашиглалтын өмнөх захиргаанд ажиллах боловсон хүчнийг ТЭЗҮ-д заагдсаны дагуу "ЭХҮТ" ТӨХХК-ийн харьяа "СҮТ"-д бэлтгэх асуудалд зохион байгуулалтаар хангаан ажиллаж байна.<br>Мөн салбарын ажиллагсдын шилжилт, хөдөлгөөний судалгааг гаргаж байна. Салбарын 27 байгууллагын **11488** ажиллагсдаас эрэгтэй **8384** буюу **72%**, эмэгтэй 3136 буюу **28%** үүнээс 2021-2022 онд шилжилт хөдөлгөөн хийсэн нийт ажиллагсдын тоо **2111** буюу **18.3** хувь нь шилжилт хөдөлгөөнтэй байна. Эрчим хүчний салбарын тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр гадаад улсад бэлтгэгдэх хүний нөөцийн хэрэгцээний судалгаа, мэдээллийг гаргаж БШУЯаманд хүргүүлсэн. | |
| 109 | **Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль-9.1.4.**<br>Жендэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулна. | Эрчим хүчний салбарын жендэрийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах | Жендэрийн бодлогын баримт бичгийг боловсруулах ажлын явц | 10% | Бодлогын баримт бичиг батлагдсан байна. | Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Эрчим хүчний сүлжээнд ашиглах чадлын хуримтлуурын төсөл"-ийн хүрээнд Эрчим хүчний салбарын жендэрийн бодлогын баримт бичгийг боловсруулах ажлыг эхлүүлж, энэ ажлын хүрээнд салбарын хэмжээнд жендэрийн нөхцөл байдал, салбарын эмэгтэй болон эрэгтэй ажилтнуудын хөдөлмөр, нийгмийн оролцоо, мэргэжлийн манлайлал зэрэг холбогдох судалгаануудыг хийсэн. Эрчим хүчний салбарын жендэрийн бодлогын бичиг баримт боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж "Монголын Хуульч эмэгтэйчүүдийн Холбоо" ТББ шалгарч хамтарсан ажлыг хэсгийг байгуулан ажилласан. Төлөвлөгөөний эхний ажил болох байгууллагуудад жендэрийн аудитыг хийх, мэдээлэл цуглуулах ажлыг хийхээр Дөрвөн зорилтот аймгийн станц, түгээх сүлжээний холбогдох байгууллагуудыг түүвэр хийж сонгон судалгаа, мэдээллийг цуглуулж дуусаад Эрчим хүчний салбарын жендэрийн нөхцөл байдлын үнэлгээг хийж ажлын хэсэгт танилцуулсан. Хамтарсан ажлын хэсгийнхэн салбарын жендэрийн стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж дуусаад яамны вэб сайтад олон нийтээс санал авахаар тавьж хуулийн хугацаа дуусмагц ЖҮХ-ны зөвлөх, экспертүүдийн хэлэлцүүлэг, Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж "Эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх жендэрийн эрх тэгш байдлыг хангах стратеги төлөвлөгөө /2023-2032/-г сайдын 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/208 дугаар тушаалаар батлуулсан. Салбарын бүх байгууллагад хэрэгжилтийг хангуулан ажиллахаар хүргүүлсэн. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг салбарын үйлдвэр, компанийн төр, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/53 дугаар тушаалаар байгуулж ажлын хэсэг ажиллаж байна. Мөн Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ОУ-ын байгууллагуудын дэмжлэг, туслалцаа авч, хамтран ажиллаж байна. НҮБ, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй Монголын эрчим хүчний засаглал USAID хөтөлбөр Жендэрийн ажлын хэсэгт орж хамтран ажиллаж байна. | 100 |
| 110 | **Төрийн албаны тухай хууль-54.1, 55.1.**<br>Байгууллагын болон төрийн албан хаагчдын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулна. | Эрчим хүчний яамны стратеги төлөвлөгөөнд үндэслэн тухайн жилийн байгууллагын болон бүтцийн нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлж дүгнэх ажлыг зохион | Хэрэгжилтийн хувиар | - | Хэрэгжилт 100% | Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" батлагдсан. Уг тогтоолын хавсралтаар баталсан журмыг хэрэгжүүлэх аргачлал, загварыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар Байгууллагын төлөвлөгөөний загварыг батласны дагуу Эрчим хүчний яамны 2021, 2022, 2023, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг бүх газар нэгжүүдээс саналыг авч нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд нь батлуулж биелэлтийг нэгтгэн тогтоосон хугацаанд гаргаж ХШҮ хийн холбогдох журмын дагуу хагас жилээр яамны удирдлагуудад, жилийн эцсээр Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ЗГХЭГ, ЗГХХГ-т тус тус хүргүүлж, ЗГ-ын ХШҮ-ний мэдээллийн нэгдсэн сан (www.unelgee.gov.mn)-д байршуулж ажилласан. | 100<br>70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах | | | | | |
| 111 | | Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлж дүгнэх, үйл ажиллагааны үр дүнд үндэслэн авах арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | ЭХЯ-ны Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГ-ын 2020 оны 218 дугаар тогтоолын хавсралтаар батлсан загварын дагуу гаргуулж батлуулах ажлыг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор хугацаанд нь зохион байгуулж, Төрийн албаны тухай хуулийн 51.1.4-т зааснаар Байгууллагын болон төрийн албан хаагчдын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. | 100<br>70 |
| 112 | **Төрийн албаны тухай хууль-66 дугаар зүйл.** Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулна. | Төрийн албан хаагчдыг ажиллах нөхцлөөр хангах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх талаар холбогдох арга хэмжээг авах, мэргэжлийн түвшинг үнэлж, дүгнэх, шатлан дэвшүүлэх, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох, нийгмийн баталгааг нь хангах асуудлыг нэгтгэн зохион байгуулах | Салбар зөвлөлийн төлөвлөгөө-ний хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Эрчим хүчний яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ажилласан.<br>Албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж Удирдлагын академийн төлөвлөгөөнд уялдуулан төлөвлөгөө гаргаж ажилласан.<br>Яамны албан хаагчдын сургалт хөгжлийн арга хэмжээнд зориулж шаардлагатай сургалтын зардлыг Сангийн яаманд уламжилж мэргэшүүлэх сургалтад сургуулийн квотоос гадна сургах ажлыг хэрэгжүүлж эхлээд байна.<br>Мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулсан.<br>-Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт,удирдах албан хаагчдын;<br>-Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад албан хаагчдын;<br>-Дунд хугацааны мэргэшүүлэх болон давтан сургалтад, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад албан хаагчдыг тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тус тус нэр дэвшүүлж хамруулсан байна.<br>Эрчим хүчний яамны төрийн албан хаагчдын хүний нөөцийн 2021, 2022, 2023 оны төлөвлөгөөг батлуулсан ажилласан.<br>Эрчим хүчний яамны төрийн албан хаагчдыг 2024-2028 он хүртэл хэрэгжиж дуусах сургалтын 4 жилийн хөтөлбөр болон 2024-2028 он хүртэл хэрэгжиж дуусах ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг тус тус 4 жилийн хугацаатайгаар шинэчилж баталдаг. 2024 оноос 2028 он хүртэл хэрэгжих хөтөлбөрийн саналыг яамны бусад газруудаас дотоод бичгээр саналыг аван газруудын хүргүүлсэн санал, болон төсөв дүнтэйгээ уялдуулан боловсруулан батлуулахаар ажиллаж байна.<br>Яамны албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, нийгмийн асуудалтай холбоотой, ажлаас чөлөөлөх, чөлөө хүсэх тухай асуудлыг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд шийдвэрлэн баталгаажуулж ажилласан.<br>-Яамны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэв олгуулах ахиулах асуудлыг Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдэл Сайдын тушаалаар олгуулсан.<br>-Албан хаагчдад Хан-Уул дүүргийн 14-р хороо ар хөндлэгийн аманд Зуслангийн газар олгох асуудлыг холбогдох төрийн байгууллагад уламжлаад байна. Мөн албан хаагчдын ажил үүргээ хэвийн явуулахад шаардагдах компьютер, техник тоног төхөөрөмжийн нарийвчилсан судалгаа гаргаж яамны албан хаагчдын компьютер, хувилагч техник хэрэгслийн шинэчлэлт хийж техник, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа бүрэн хангагдсан.<br>Тус яамны нийт албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталж мөрдлөг болгон ажилллаж байна. | 100<br>70 |
| 113 | **Монгол Улсын Засгийн газрын тухай-24.1.4.** | Эрчим хүчний сайдаас Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Эрчим хүчний сайдаас аймаг, нийслэлийн Засаг даргатай жил бүр байгуулдаг Хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийг аймгийн ЗДТГ-аас гаргуулан авч 2 талын үүргийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журамд заасны дагуу хяналт- | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын үйл ажиллагааг чиглүүлж удирдана. | Хамтран ажиллах гэрээ байгуулах, дүгнэх ажлыг нэгтгэн зохион байгуулах | | | | шинжилгээ хийж, үнэлгээ өгөн жил бүрийн 03 дугаар сарын 01-ний дотор багтаан ЗГХЭГ-т тайлагнаж ажилласан. | |
| 114 | **Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль -34 дүгээр зүйл.**<br>Яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулна. | Яамны албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, төрийн албаны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | Хуулийн хэрэгжилтээр | - | Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна | Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, хүсэлтийн хайлтын программд скайнердан, бүртгэн шивж оруулах, яамны удирдлага болон газар, хэлтсүүдэд биечлэн хүлээлгэн өгч танилцуулан ажилласан. Төрийн дээд байгууллага болон үйлдвэр, ААН, компаниудаас ирсэн 4 жилд дунджаар 4000 албан бичиг, Явсан бичиг-2200, Нийт 150 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг албан хэрэг хөтлөлт, өргөдөл, хүсэлтийн хайлтын программд скайнердан, бүртгэн шивж оруулах, яамны удирдлага болон газар, хэлтсүүдэд биечлэн хүлээлгэн өгч танилцуулж байна. Мөн Яамны байгууллагын архивт байгаа нийт 30,000 гаруй хадгаламжийн нэгжид нэмж 800 гаруй боть баримт бүртгэлээр татан авалт хийж, стандартын дагуу хадгалагдан ажлын хэрэгцээнд ашиглагдаж байна. Мөн ажилтан, албан хаагчдад ажлын хэрэгцээнд 1 жилд дунджаар 800 боть, 2340 гаруй хуудас албан бичиг, тушаал хуулбарлан бүртгэлээр олгосон. | 100 |
| 115 | **Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль-15 дугаар зүйл.**<br>Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэнэ. | Бичгээр ирсэн болон Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төвөөр дамжин цахим хэлбэрээр ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэх ажлыг хэрэгжүүлэх, зохион байгуулах | Хуулийн хэрэгжилтээр | - | Хуулийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна. | Иргэд аж ахуйн нэгжүүдээс тус яаманд ирсэн өргөдөл гомдлыг судалж, шийдвэрлүүлэх ажилд тогтмол хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд тайлан тогтоосон хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлэн ажиллаж байна.<br>Тус яаманд тайланд хугацаанд жилд нийт 150 гаруй өргөдөл гомдол ирсэн байх бөгөөд шийдвэрлэлт 90% байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг тогтоосон хугацаанд гаргаж ЗГХЭГ-т хүргүүлэхээр ажиллаж байна. | 90<br>70 |
| 116 | **Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль-8.2, 9.10.**<br>Сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарыг үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нь эрхлэх асуудлын хүрээний чиглэлээр зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ. | Сайд, төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилтийг бүрэн хангасан байна. | Сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарыг үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нь эрхлэх асуудлын хүрээний чиглэлээр зөвлөгөө дэмжлэг үзүүлж ажиллалаа.<br>Сайдын зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулж зөвлөлийн гишүүдэд хэлэлцэх асуудлын материалыг тараан хуралдааны дэлгэрэнгүй протокол болон тэмдэглэлийг цаг тухайд нь албажуулж, батлуулан холбогдох албан тушаалтан, байгууллагуудад хүргүүлж ажиллав.<br>Салбарын шуурхай зөвлөгөөний хуралдааныг тухай бүрт нь зохион байгуулан түүнээс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг өгөгдсөн газруудаас авах нэгтгэж хагас, бүтэн жилийн байдлаар тайлангуудыг тогтоосон хугацаа бүрт нь гаргаж өгсөн. | 70 |
| 117 | | Салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулах, зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийн үр дүн, нөлөөллийг үнэлэх | Зөвлөгөөний шийдвэрээс хэрэгжүүлсэн сайн саналын тоо | - | 4-өөс доошгүй саналыг хэрэгжүүлсэн байна. | Салбарын удирдах ажилтны зөвлөлгөөн зохион байгуулаагүй болно. Эрчим хүчний салбарын үүсч хөгжсөн 100,101 жилийн ойг 2023 оны тэмдэглэн өнгөрүүлсан байна. | 0 |
| 118 | | Захиргааны актгай холбогдуулан гарсан шүүхийн нэхэмжлэлд яамыг төлөөлөх, холбогдох эрх зүйн | Хууль тогтоомжид нийцсэн байна. | - | Хууль тогтоомжид нийцсэн байна. | 2024 оны хагас жилийн байдлаар:<br>Эрчим хүчний сайд, Эрчим хүчний яаманд холбогдуулан гаргасан Захиргааны хэргийн **4,** Иргэний **4** хэрэг маргаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, иргэний **1** хэрэгт нэхэмжлэгчийн төлөөлөгчөөр, Арбитрийн **1** маргаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр тус газрын албан хаагчид томилогдон ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | туслалцаа үзүүлэх | | | | Тус яамтай холбогдуулан гаргасан нэхэмжлэлтэй захиргааны болон иргэний хэргүүдэд яамыг төлөөлөн оролцож, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байна. | |
| ***Д.2. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомж, бусад шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 119 | **Яамны эрх зүйн байдлын тухай хууль-15.1.2.** Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэх бүх шатанд тайлбар, зөвлөгөө өгнө. | Салбарын бодлого, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан яамнаас УИХ, Засгийн газар, бусад холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэхээр хүргүүлэх эрх зүйн актын төслийг хянах, дэмжлэг үзүүлэх | Хууль тогтоомжид нийцсэн байна. | - | Хууль тогтоомжид нийцсэн байна. | 2024 оны хагас жилийн байдлаар:<br>Салбарын бодлого, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус яамнаас Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх Засгийн газрын тогтоолын төсөл **2**, Засгийн газрын хуралдааны **5** тэмдэглэлийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянан, яамны газруудад хууль зүйн дэмжлэг, арга зүйн туслалцаа үзүүлэв. | 100 |
| 120 | | Хууль санаачлагчдаас ирүүлсэн хууль, тогтоомжийн төслийг салбарын чиг үүрэгтэй уялдуулах чиглэлээр санал боловсруулах | Хууль тогтоомжид нийцсэн байна. | - | Тодорхой санал өгсөн байна. | 2024 оны хагас жилийн байдлаар:<br>Улсын Их Хурал, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал авахаар ирүүлсэн хуулийн төсөлд болон Засгийн газрын тогтоолын нийт **263** төсөлд холбогдох саналыг боловсруулж, хүргүүлэв. | 100 |
| 121 | **Засгийн газрын тухай хууль-24, Яамны эрх зүйн байдлын тухай хууль-9.6.** Сайд, төрийн нарийн бичгийн даргын тушаалын хууль зүйн үндэслэлийг хангана. | Сайд, төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийг боловсруулахад хууль зүйн үндэслэлийг хянах, дэмжлэг үзүүлэх | Эрх зүйн актын хуульд нийцсэн байдал | - | Хууль зүйн зөрчилгүй байх | 2024 оны хагас жилийн байдлаар:<br>Эрчим хүчний сайдын **138**, ТНБД-ын **197** тушаалын төслийн хууль зүйн үндэслэлийг хянав.<br>Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төсөл боловсруулах, тэдгээрийг боловсруулахад яамны газруудад тухай бүр зөвлөгөө өгч ажиллав. | 100 |
| 122 | | Эрчим хүчний салбарын хэмжээнд мөрдөгдөх захиргааны хэм хэмжээний актыг боловсруулахад хууль зүйн дэмжлэг үзүүлэх, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах | Хууль тогтоомжид нийцсэн байна. | - | Нэгдсэн сан бүрдсэн байна. | 2024 оны хагас жилийн байдлаар:<br>-Улсын нэгдсэн сангийн бүртгэл хөтлөн ажиллаж байгаа бөгөөд Эйбл программын Олон нийт хэсэгт "Захиргааны хэм хэмжээний актын сан" нэртэй хавтас үүсгэн улсын нэгдсэн санд бүртгэлтэй, эрчим хүчний салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт **35** захиргааны хэм хэмжээний актыг файлын хамт байршуулсан болно.<br>Мөн яамны цахим хуудсанд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй, эрчим хүчний салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа захиргааны хэм хэмжээний акт гэсэн шинэ цэс үүсгэж дээрх захиргааны хэм хэмжээний актуудтай шууд танилцах холбоосыг байршуулсан болно.<br>-Эрчим хүчний салбарт хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийн тайлангжил бүр гаргаж ХЗДХЯ-нд тайлагнан ажиллаж байна.<br>-Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 4378 дугаар бүртгэлтэй, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрчим хүчний сайдын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 125 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам”-ын есдүгээр хавсралт болох Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын явцад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтын доод хэсэгт “1.*тэмдэглэгээ бүхий баримт бичгүүд боловсруулагдаж байгаа болно.” дурдсан бөгөөд “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-аас Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын явцад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтын “7.Дулааны цахилгаан станц, Дулааны станц*” хэсэгт оруулах акт, протоколын жагсаалтыг боловсруулан тус яаманд ирүүлсэн.<br>Эрчим хүчний сайдын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 125 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам”-ын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын явцад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтын "7.Дулааны цахилгаан станц, Дулааны станц*" хэсэгт оруулах акт, протоколын жагсаалтыг боловсруулахдаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/147 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал"-ын дагуу дараах нөлөөллийн шинжилгээг гүйцэтгэж, "Жагсаалт шинэчлэн батлах тухай" тушаалын төсөл боловсруулж, Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/31 дүгээр тушаалын төсөл боловсруулж, батлуулан Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.3 дахь хэсэгт заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр Эрчим хүчний сайдын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн а/1751 тоот албан бичгээр Хууль, зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Эрчим хүчний сайдын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн "Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам"-ын есдүгээр хавсралтад нэмэлт оруулах тухай А/125 дугаар тушаалыг үндэслэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөн хийсэн тухай Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 1/3112 тоот албан бичиг ирүүлсэн болно.<br>Захиргааны хэм хэмжээний актын талаар слайдууд бэлтгэн Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын захиргааны болон хуулиийн асуудал мэргэжилтнүүдэд Захиргааны хэм хэмжээний актын талаар мэдээлэл өгч, сургалт зохион байгуулсан.<br>Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлгүй захиргааны хэм хэмжээний акт байхгүй болно. | |
| 123 | **Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль.**<br>Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулна. | Албан тушаалтан, төрийн жинхэнэ албан хаагчдын хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулах, хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах | Хуулийн хэрэгжилтээр | - | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | 2024 оны хагас жилийн байдлаар:<br>Эрчим хүчний яам болон эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын мэдүүлэг гаргавал зохих мэдүүлэгчдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд холбогдох албан хаагч нараас гаргуулж, хянан баталгаажуулан ажилласан.<br>Эрчим хүчний яамны албан хаагчид болон Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын захирлуудын нийт **171** ХАСХОМ мэдүүлгийг хуулийн хугацаанд хянан баталгаажуулсан.<br>Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс зохион байгуулсан 2024 онд шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтад шинээр томилогдсон ЭБАТ-уудыг хамруулсан. | 100 |
| 124 | | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг салбарын хэмжээнд зохион байгуулах, тайлагнах | Хөтөлбөрийн хэрэгжилтээр | - | Хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна. | Эрчим хүчний яамны 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/76 тоот тушаалаар батлуулсан.<br>Эрчим хүчний яам болон Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар хүлээн авч, khutulbur.iaac.mn цахим сангийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө цэсэнд хугацаанд нь /2024.07.05-ны өдрийн дотор/ байршуулахаар ажиллаж байна.<br>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа талаар болон зөвлөмжүүдийг эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудад цаг хугацаанд нь хүргүүлэн чиглэл өгч, ажилласан. | 70 |
| ***Д.3. Салбарын төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг зохион байгуулах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 125 | **Компанийн тухай хууль.**<br>Компанийн тухай хуулийн хэрэгжилтийг хангана. | Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулах, төрийн | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилтийг хангасан байна. | 2024 оны хагас жилийн байдлаар:<br>Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын төрийн өмчийн төлөөллийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн "Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | өмчит компаниудыг нэгдсэн удирдамжаар хангах | | | | тухай" 01 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд зохион байгуулан ажилласан.<br>Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Эрчим хүчний салбарын 27 төрийн өмчит хувьцаат компанийн 189 асуудлыг хэлэлцсэн.<br>Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит 1 болон ээлжит бус 4 удаагийн хурлыг зохион байгуулсантай холбогдуулан хурлаас гарсан шийдвэрийн төслийг бэлтгэж, ээлжит болон ээлжит бус хурлаас гарсан нийт 210 шийдвэрийг албажуулж батлуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт хүлээлгэн өгч ажилласан. | |
| 126 | | Салбарын төрийн өмчит компаниудад компанийн засаглалын бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, удирдамжаар хангах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилтийг хангасан байна. | 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл Эрчим хүчний салбарын 26 төрийн өмчит хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудалд нийт 69 удирдамжийг боловсруулан батлуулж хүргүүлсэн.<br>Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын үйл ажиллагаанд тухай бүр зөвлөмж, арга зүйн туслалцаа өгч, телеграм чат группээр мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэн ажилласан. | 100 |
| ***Д.4. Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 127 | **Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль-14.1.** Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглоогүй мэдээллээр иргэн, хуулийн этгээдийг хангана. | Хууль, тогтоомж, дээд газруудын шийдвэр, эрчим хүчний талаарх бодлого, хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилт, салбарын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар сурталчлах, олон нийтийг мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Мэдээллийн тасралтгүй байдлыг чанаржуулж, хэрэгжилтийг 100 хувь хангасан байна. | Эрчим хүчний сайд, дэд сайд, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлттэй холбоотой олон нийтийг хамарсан арга хэмжээ, салбарын хэмжээнд болон олон нийтэд сурталчлан таниулах зэрэгт хэвлэл мэдээллийн байгууллагуудтай холбогдож ажиллалаа. Телевиз, сайт, сонин, радио гэх мэт хэвлэл мэдээллийн байгууллагын редакцид хандаж цаг алдалгүй мэдээлэл түгээн ажиллаж байгаа болно.<br>Салбарын хэмжээнд бүтээн байгуулалтын ажлууд өрнөж, шинэ эх үүсвэр болон өргөтгөлүүд ашиглалтад орсныг дангаар болон Ерөнхийлөгчийн тамгийн газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын олон нийт, мэдээлэлтэй харьцах хэлтэстэй хамтран түгээн ажиллалаа.<br>Шинэ эх үүсвэр болон өргөтгөлүүд ашиглалтад орсныг тухай бүрт хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулж ажилласан.<br>Тухайлбал, сүүлийн байдлаар 80МВт-ын хүчин чадалтай том чадлын батарей хуримтлуурын төсөл амжилттай хэрэгжсэн, Дорнод бүсэд шинээр 50МВт-ын дулааны цахилгаан станц ашиглалтад орсон, Амгалангийн дулааны станцыг 116МВт-аар өргөтгөснөөс гадна Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын санхүүжилт шийдэгдэж, цаашид барилга угсралтын ажил төлөвлөсөн хугацаандаа явагдах нөхцөл бүрдээд байна. Мэдээ мэдээлэл бэлдүүлэхээс гадна хэлэлцүүлэг, ярилцлага, асуудал хөндсөн сэдэв зэрэг буланд оролцуулан өргөн цар хүрээнд түгээж ажилласан. | 100 |
| 128 | | Мэдээ, мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр сан үүсгэх, баяжуулах, аюулгүй байдлыг сайжруулах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Архивын хөмрөг өргөжсөн байна. | Мэдээллийн цахим хуудаснаас мэдээ, мэдээлэл, хууль тогтоомж, тушаал шийдвэрийг цаг тухай бүрд цахим хувилбараар оруулан хадгалдаг. Мөн архивын санд цаасан хэлбэрээр төрөлжүүлэн хадгалах, шинэчлэх ажлыг тогтмол хийж байна. | 100 |
| 129 | **ЗГҮАХХАХТ-4.1.3.** Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, | ЗГҮАХХАХТ-4.1.3.3, Төрийн цахим үйлчилгээний e-Mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилтийг хангасан байна. | Зөвшөөрлийн тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн www.license.energy.gov.mn цахим системд бүрэн шилжүүлэн сар бүрийн 5-ны өдрөөс ажлын 10 хоногт хүсэлтийг хүлээн авч, ажлын хэсэг магадлан шалгаж, шаардлагуудыг хангасан байгууллагуудыг Эрчим хүчний сайдын тушаалаар баталж, тухай бүр системд шинэчлэлт хийж ажиллаж байна.<br>Тус систем нь e-business, e-mongolia.mn болон ХУР-д хэд хэдэн сервис гаргасан бөгөөд тусгай зөвшөөрлийн нэгдсэн цахим систем буюу www.license.mn-д Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, угсралт, засварын ажил, туршилт тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг тогтмол оруулж ажилласан. Цахилгаан, дулааны техникийн нөхцөлийн хүсэлтийг www.itc.energy.mn | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөлттэй хөгжүүлнэ. | | | | | цахим системээр сар бүрийн 1-ний өдрөөс 10-ны өдрийн хооронд тогтмол хүлээн авч ажиллаж байна. Системийн хөгжүүлэлттэй холбоотой өгөгдлийн санг шинэчлэх сайжруулах тус системийг хөгжүүлэн /e-mongolia.mn, e-business.mn, operator.e-mongolia.mn-д нэвтрүүлж Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу “И Монгол академи” ТӨҮГ-тай хамтран “E-Mongolia”, “E-gazar” болон төрийн мэдээлэл үйлчилгээний “Хур” систем, “ДАН” системтэй холбогдон www.itc.energy.mn цахим системийг хөгжүүлэн, 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс ашиглалтад оруулан, цахилгаан, дулааны техникийн нөхцөлийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна.<br>e-mongolia”, “e-gazar” болон “Хур” системтэй цахилгаан болон дулааны техникийн нөхцөлийн www.itc.energy.mn цахим системийн хэрэглэгчид зориулсан туршилт нэвтрүүлэлт гарын авлага хийх, системийн хөтөч бичлэг зааварчилгааг цахим системд цаг тухай бүрд шинэчлэн сайжруулалт хийж нээлттэй байршуулан ажиллаж байна.<br>www.itc.energy.mn цахим системийг хөгжүүлэн хөгжүүлэлттэй холбоотой өгөгдлийн санг шинэчлэх сайжруулах тус системийг хөгжүүлэн /e-mongolia.mn, e-business.mn, operator.e-mongolia.mn-д нэвтрүүлж Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан. | |
| Е. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ, ЗАРЦУУЛАХ, ДОТООД, ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХАД БҮХ ТАЛЫН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ЯАМНЫ АППАРАТЫН САНХҮҮГИЙН ӨДӨР ТУТМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАРИУЦАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| ***Е.1. Эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, концесс, төсөл хөтөлбөрийн үр ашгийг дээшлүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, хяналт тавьж ажиллах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 130 | **Эрчим хүчний тухай хууль-5.1.**<br>Салбарын эдийн засгийн төлөвлөлт, үнэ, тариф, өрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлнэ. | Салбарын үйлдвэр, компаниудын санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, санхүүгийн чадавхийг дээшлүүлэх, зорилтот түвшингийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Эрчим хүчний сайдын 2023 оны А/3853 удирдамжийн дагуу боловсруулсан ТӨХК-ийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажил болон бизнес төлөвлөгөөтэй танилцан ажлын хэсгийн гаргасан санал, зөвлөмжийн дагуу нийт 27 компанийн техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин баталсан. Үүнд нийт орлогын төлөвлөгөөг 3,267.6 тэрбум төгрөг, нийт зардал 3,416.4 тэрбум төгрөг, 148.9 тэрбум төгрөгийн алдагдалтай, их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлыг 175.4 тэрбум төгрөгөөр тус тус баталсан. Салбарын үйлдвэр, компаниудын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан тайлан баланс, эдийн засгийн үндсэн үзүүлэлт гарсантай холбогдуулан зорилтот түвшин батлуулсан 27 төрийн өмчит үйлдвэр, компанийн 2023 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлтийг нэгтгэн, хэмнэлт хэтрэлтэд дүн шинжилгээ хийж үр дүнг тайлагнасан. Зорилтот түвшингийн нэгтгэлээр орлогын төлөвлөгөө 3,191.0 тэрбум төгрөг буюу 5,8 хувиар, зардал 3,195.6 тэрбум төгрөг буюу 3,7 хувиар өсөж 11,5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу батлагдсан зорилтот түвшингээс 82,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтаар 164,4 тэрбум төгрөг буюу 71,2 хувийн гүйцэтгэлтэй ажил хийгдсэн байна.<br>2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсанаар нийт авлага 160.3 тэрбум төгрөг, богино хугацаат өр төлбөр 240.7 тэрбум төгрөг, урт хугацаат өр төлбөр 1,510.8 тэрбум төгрөг байна. Санхүүгийн хүндрэл үүсэх ТӨХК-иудын удирдлагатай танхим болон цахимаар уулзалт хийж өр, авлагыг богино хугацаанд барагдуулах талаар үүрэг чиглэл өгсөн. “Нэг худалдан авагчтай загвар”-т төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх талаар холбогдох компаниудад албан бичиг хүргүүлсэн. | 70 |
| 131 | **Олон Улсын гэрээ, хэлэлцээр.**<br>Гадаадын зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана. | Төсөл, хөтөлбөрүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтын тооцоог хийж, төсөвт | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Холбогдох арга хэмжээ авсан байна. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025 оны төсвийн хязгаарын санал “Эгийн голын УЦС”, “Эрдэнэбүрэнгийн УЦС” болон “10 аймгийн төвийн ДС барих төсөл”-үүдэд холбогдох зардлыг тусгуулахаар саналыг нэгтгэн боловсруулж Эрчим хүчний сайдын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн а/1772 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тусгуулах | | | | | |
| 132 | | Төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулах, бодлогын удирдамжаар хангах, ажлын хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Гадаадын зээл тусламжаар хэрэгжих буй төсөл хөтөлбөрийн өдөр тутмын үйл ажиллагааг хүний нөөц, санхүүжилт, татварын хөнгөлөлт зэрэг асуудлыг шийдвэрлэхэд бодлогын удирдамжаар хханган ажиллаж байна. | 70 |
| ***Е.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв боловсруулах, улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангах, худалдан авалтын үйл ажилгааг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 133 | **Төсвийн тухай хууль-14.** Төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн төсвийн төслийг боловсруулах, зохицуулах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг хангана. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын санал, төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, тухайн оны төсвийн төсөл, ирэх жилийн төсвийн төсөөллийг боловсруулах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | -Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025 оны төсвийн хязгаарын саналыг боловсруулж Эрчим хүчний сайдын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн а/1772 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 2024 оны батлагдсан төсвийн гүйцэтгэл санхүүжилт 20.9 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>-Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын тусгагдсан Эрчим хүчний салбарт 2024 онд шинээр эхлэн хэрэгжих 35 төсөл, арга хэмжээнүүдийн БУА-ын гүйцэтгэгчтэй гэрээний хэлцэл хийж гэрээ байгуулахаас 2024 оны хагас жилийн байдлаар 13 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.<br>-Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад тусгагдсан Эрчим хүчний салбарт өмнөх онуудоос шилжин хэрэгжих 20 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянан баталгаажуулах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлж 2024 оны эхний хагас жилийн байдлаар 49.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. | 100 |
| 134 | **ТБОНӨХБАУХАТ хууль.** Төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтийг хангуулна. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулагдсан байна. | -Эрчим хүчний сайдын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 252 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагаар зохион байгуулахаар Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 25 үнэлгээний хороог байгуулж, холбогдох хууль журмын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/-ээр нийт 22 төсөл, арга хэмжээний 34 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулан хэрэгжилтийг хханган ажиллаж байна.<br>-Эрчим хүчний яамны харьяа гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл", "Сэргээгдэх Эрчим хүчний халаалтын системийн туршилтын төсөл", "Сэргээгдэх Эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл"-ийн нэгжүүдийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу тухай бүрд 11 үнэлгээний хороо байгуулан ажилласан. | 70 |
| ***Е.3. Яамны аппаратын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах, яамны мөнгөн урсгалыг оновчтой төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавих үндсэн чиг үүргийн хүрээнд:*** | | | | | | | |
| 135 | **Төсвийн тухай хууль-14.** Яамны аппаратын санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах, | Яамны урсгал зардлыг батлагдсан хуваарийн дагуу олгох, яамны төрийн сангийн үйл ажиллагааг зохион | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Эрчим хүчний яамны урсгал зардлын санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу зарцуулахад анхан шатны баримтуудын эх хувийг үндэслэн хөтөлбөр, зориулалт, зардлын бүлэг, эдийн засгийн ангиллыг хянаж, өдөр тутмын гүйлгээг Төрийн сангийн удирлагын системд гүйлгээг шивж, цахим гарын үсгээр баталгаажуулан ажиллаж байна. Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2024 оны урсгал зардал 111,070.08 сая төгрөгийн төсөвтэй, 53,795.00 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 48 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлагнах, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангана. | байгуулах, эрчим хүчний үйлдвэрүүдийн татаасын санхүүжилтийг хийх | | | | Мөн 2024 оны Эрчим хүчний сайдын багцад эрчим хүчний үйлдвэр компаниудын татаасын санхүүжилт тусгагдсан бөгөөд батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг олгож байна. | |
| 136 | | Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргах, аудит хийлгэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Төсвийн шууд захирагчийн 2023 оны Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн в/272 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Үндэсний аудитын газраас тус яамны Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсан.<br>ТЕЗ-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайланг 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүлээн авч, ТЕЗ-ийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргасан.<br>Эрчим хүчний сайдын багцын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг аудит хийлгэхээр МУ-ын ерөнхий аудиторт Сайдын 2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн а/988 дугаартай албан бичгээр хүргүүлж аудит хийлгэн, 2024 оны 04-р сарын 25-ны өдрийн а/1230 тоот албан бичгээр хүргүүлж аудитлагдсан тайланг Засгийн газрын тайланд нэгтгүүлсэн. | 100 |
| 137 | | Яамны үндсэн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, тайлагнах | Үйл ажиллагааны хэрэгжилтээр | - | Хэрэгжилт 100% | Удирдлагын зөвшөөрсний дагуу худалдан авсан эд хөрөнгө, бараа материал шилжиж ирсэн үндсэн хөрөнгийг орлогод хүлээн авч бүртгэн хөтөлж, холбогдох эзэмшигч бүрт хөрөнгийн картыг нээн бүртгэж, гарын үсэг зуруулан хүлээлгэн өгч ажиллаа. Үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийг орлогод авахдаа хөрөнгийн ангилал хийж, ашиглалтад орсон он сар өдөр, ашигласан хугацаа зэргийг анхан шатны баримттай нь тулган нягтлан бодох бүртгэлийн программд цаг тухай бүр нь оруулан тооцоо, тайланг сар бүрээр хийж, шаардлагатай тайлан мэдээг удирдлагуудад гарган танилцуулан ажиллаж байна. 2024 оны 06 дугаар сарын байдлаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 6 нэр төрлийн, 1609,8 ширхэг 5,890,831,054.11 төгрөгийн үлдэгдэлтэй, 321.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийж 32.18 сая төгрөгийн орлогын гүйлгээ хийн 417 нэрийн 563 ширхэг хөрөнгийг дахин үнэлж бүртгэж балансад бүртгэж авсан.<br>2024 оны хагас жилийн хөрөнгийн тооллогыг хийх бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 100 |
| 138 | | Төсвийн шууд захирагчийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Хуулийн хэрэгжилтээр | - | Хуулийн хэрэгжилтийг хангасан байна. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн хугацаанд мэдээллүүдийг бүрэн байршуулан ажиллаж байна. | 90 |
| | | | | | | **ДҮН** | **78.3** |

---oOo---